



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
ЗОХИЦУУЛАХ
ХОРОО



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН 2023 оны СТАТИСТИК ЭМХЭТГЭЛ

Улаанбаатар 2024

Эмхэтгэлийг боловсруулсан
Харилцаа холбооны зохицуулах хорооны
Зах зээл үнэ тарифын зохицуулалтын газар
Судалгаа, шинжилгээний хэлтэс
www.crc.gov.mn
11-304258

2024 он

Агуулга

Хүснэгтэн мэдээллийн жагсаалт	v
Зурган мэдээллийн жагсаалт.....	vii
1. Танилцуулга	1
2. Тусгай зөвшөөрөл	4
3. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд.....	6
3.1 Харилцаа холбооны үйл ажиллагааны орлого	6
3.2 Төсөвт төвлөрүүлсэн орлого	8
3.3 Хөрөнгө оруулалт.....	9
4. Харилцаа холбооны сүлжээ	11
4.1 Харилцаа холбооны сүлжээний үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт	12
4.2 Харилцаа холбооны сүлжээний урт	13
4.3 Улс хоорондын сүлжээний үйлчилгээ	15
4.4 Улс хоорондын транзит үйлчилгээ	15
4.5 Сансрын холбооны сүлжээ, үйлчилгээ	16
5. Үүрэн холбооны үйлчилгээ	17
5.1 Үүрэн холбооны үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт	18
5.2 Үүрэн холбооны хэрэглэгчийн тоо.....	20
5.3 Үүрэн холбооны ачаалал/хэрэглээ.....	27
5.3.1 Ярианы ачаалал.....	27
5.3.2 Мессеж ба дата хэрэглээ	28
6. Суурин интернэт үйлчилгээ	30
6.1 Суурин интернэт үйлчилгээний орлого	30
6.2 Суурин интернэт хэрэглэгчийн тоо	32
6.3 Суурин интернэтийн хэрэглээ.....	35
7. Суурин телефон үйлчилгээ.....	35
7.1 Суурин телефон үйлчилгээний орлого.....	36
7.2 Суурин телефон хэрэглэгчийн тоо.....	38
7.3 Суурин телефон үйлчилгээний ачаалал.....	39
8. Өргөн нэвтрүүлэг - Олон суваг дамжуулах үйлчилгээ.....	40
8.1 Олон суваг дамжуулах үйлчилгээний орлого.....	40
8.2 Олон суваг дамжуулах үйлчилгээний хэрэглэгчийн тоо	42
9. Телевизийн үйлчилгээ	46
10. Радиогийн үйлчилгээ.....	50

11.	Шуудангийн үйлчилгээ	52
11.1	Шуудангийн үйлчилгээний орлого	53
11.2	Шуудангийн илгээмж солилцоо.....	55
11.2.1	Дотоодын шуудангийн илгээмж солилцоо	55
11.2.2	Улс хоорондын шуудангийн илгээмж солилцоо.....	56
12.	Хүний нөөц	57
	Хавсралт	60

Хүснэгтэн мэдээллийн жагсаалт

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрлийн шийдвэрийн мэдээлэл, оноор	4
Хүснэгт 2. Харилцаа холбооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо, төрлөөр (2023 оны жилийн эцсийн байдлаар)	5
Хүснэгт 3. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн орлого, үйл ажиллагааны чиглэлээр (тэрбум төгрөг)	7
Хүснэгт 4. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн төсөвт төвлөрүүлсэн орлого, үйл ажиллагааны чиглэлээр (тэрбум төгрөг)	8
Хүснэгт 5. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн хөрөнгө оруулалтын хэмжээ, тусгай зөвшөөрлийн төрлөөр (тэрбум төгрөг)	10
Хүснэгт 6. Харилцаа холбооны сүлжээ байгуулах, эзэмших, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн жагсаалт, үйлчилгээний төрлөөр, 2023	11
Хүснэгт 7. Харилцаа холбооны сүлжээний үйлчилгээний төрлүүд	12
Хүснэгт 8. Харилцаа холбооны сүлжээний үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт, сүүлийн 3 жилийн өөрчлөлт	13
Хүснэгт 9. Харилцаа холбооны хот, хот хоорондын дамжуулах сүлжээний урт (км), оноор	13
Хүснэгт 10. Шилэн кабелийн сүлжээний урт (км), 2023 он	14
Хүснэгт 11. Улс хоорондын нийт транзит урсгал ба орлогын хэмжээ, оноор	16
Хүснэгт 12. Сансрын холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн орлого, сүүлийн 3 жилийн өөрчлөлт	16
Хүснэгт 13. Сансрын холбооны үйлчилгээний хэрэглэгчийн тоо	17
Хүснэгт 14. Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчдийн зах зээлд эзлэх хувь	17
Хүснэгт 15. Үүрэн холбооны үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт, сүүлийн 3 жилийн өөрчлөлт	18
Хүснэгт 16. Үүрэн холбооны үндсэн үйлчилгээний орлогын бүтэц	19
Хүснэгт 17. Үүрэн холбооны нэвтрэлтийн түвшин	21
Хүснэгт 18. Хөдөлгөөнт өргөн зурвасын хэрэглэгчийн тоо	21
Хүснэгт 19. Үүрэн холбооны бааз станцын тоо, технологийн төрлөөр	22
Хүснэгт 20. Үүрэн холбооны хэрэглэгчдийн тоо бүс, байршлаар, 2023 он	23
Хүснэгт 21. Үүрэн холбооны үйлчилгээний нэг хэрэглэгчийн сарын дундаж дата хэрэглээ	29
Хүснэгт 22. Хөдөлгөөнт өргөн зурвасын смарт бокс ашиглан үйлчилгээ авч буй хэрэглэгчийн тоо	30
Хүснэгт 23. Суурин интернэтийн үйлчилгээ эрхлэгчийн зах зээлд эзлэх хувь, идэвхтэй хэрэглэгчийн тоогоор	30
Хүснэгт 24. Суурин интернэт үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт, сүүлийн 3 жилийн өөрчлөлт	31
Хүснэгт 25. Суурин интернэт хэрэглэгчийн тоо, хот, аймаг бүсээр	34
Хүснэгт 26. Суурин интернэт үйлчилгээний нэг хэрэглэгчийн сарын дундаж хэрэглээ	35
Хүснэгт 27. Суурин телефон үйлчилгээ эрхлэгчийн зах зээлд эзлэх хувь, идэвхтэй хэрэглэгчийн тоогоор, 2023 он	36
Хүснэгт 28. Суурин телефон үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт, сүүлийн 3 жилийн өөрчлөлт	36
Хүснэгт 29. Суурин телефон хэрэглэгчийн тоо, хэрэглэгчийн төрлөөр, 2023 он	38
Хүснэгт 30. Суурин телефон хэрэглэгчийн тоо, байршлаар	39
Хүснэгт 31. Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн зах зээлд эзлэх хувь, идэвхтэй хэрэглэгчийн тоогоор, 2023 он	40

Хүснэгт 32. Олон суваг дамжуулах үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт, сүүлийн 3 жилийн өөрчлөлт.....	41
Хүснэгт 33. АйПиТВ үйлчилгээний хэрэглэгчийн тоо, төрлөөр	44
Хүснэгт 34. Олон суваг дамжуулах үйлчилгээний хэрэглэгчийн тоо, хот, аймаг бүсээр	45
Хүснэгт 35. Телевизийн тусгай зөвшөөрлийн тоо, төрөл, хамрах хүрээгээр	46
Хүснэгт 36. Телевизийн үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт,	47
Хүснэгт 37. Телевизийн үйлчилгээний 2023 оны орлого /Тэрбум төгрөг/.....	48
Хүснэгт 38. Телевизийн үйлчилгээний 2023 оны орлогын бүтэц.....	48
Хүснэгт 39. Өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн 2023 оны орлогын бүтэц.....	49
Хүснэгт 40. Арилжааны телевизүүдийн 2023 оны орлогын бүтэц	49
Хүснэгт 41. Радиогийн тусгай зөвшөөрлийн тоо, төрөл, хамрах хүрээгээр	50
Хүснэгт 42. Радиогийн үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт, сүүлийн 3 жилийн өөрчлөлт	51
Хүснэгт 43. Радиогийн үйлчилгээний 2023 оны орлого, байршлаар	51
Хүснэгт 44. Радиогийн үйлчилгээний орлогын бүтэц, 2023 он.....	51
Хүснэгт 45. Шуудангийн тусгай зөвшөөрлийн тоо	52
Хүснэгт 46. Шуудангийн сүлжээ байгуулах тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн жагсаалт, үйлчилгээний төрлөөр, 2023.....	52
Хүснэгт 47. Улс хоорондын илгээмжийн үйлчилгээ үзүүлж буй чиглэл, үйлчилгээ эрхлэгчийн тоо, 2023 он.....	53
Хүснэгт 48. Шуудангийн үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт, сүүлийн 3 жилийн өөрчлөлт	53
Хүснэгт 49. Нийт шуудангийн илгээмж солилцооны тоо	55
Хүснэгт 50. Дотоодын шуудангийн илгээмж солилцооны тоо.....	55
Хүснэгт 51. Дотоодын буухиа шуудан солилцооны тоо	55
Хүснэгт 52. Улс хоорондын шуудан солилцооны тоо	56
Хүснэгт 53.Улс хоорондын буухиа шуудан солилцоо.....	56
Хүснэгт 54. Нийт ажилтны тоо, салбар болон үйлчилгээний төрлөөр.....	57
Хүснэгт 55. Нийт ажиллагчдын тоо, мэргэжлээр	59

Зурган мэдээллийн жагсаалт

Зураг 1. Зөвшөөрлийн тоо, оноор.....	4
Зураг 2 Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, 2020-2023 он.....	6
Зураг 3. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн орлого, оноор	6
Зураг 4. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн төсөвт төвлөрүүлсэн орлого, оноор (тэрбум төгрөг)	8
Зураг 5. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн хөрөнгө оруулалтын хэмжээ, оноор	10
Зураг 6. Харилцаа холбооны сүлжээний үйлчилгээний орлого, оноор	12
Зураг 7. Хот хоорондын шилэн кабелийн сүлжээний эзэмшил, 2023.....	14
Зураг 8. Интернэтийн бөөний үйлчилгээ эрхлэгчдийн нийт урсгалын багтаамж: Гбит/сек .	15
Зураг 9. Сансрын холбооны үйлчилгээний орлого, оноор /тэрбум төгрөг/.....	16
Зураг 10. Үүрэн холбооны нийт орлого /тэрбум.төг/	18
Зураг 11. Үүрэн холбооны нэг хэрэглэгчээс олох дундаж орлого (ARPU) /төг/	19
Зураг 12. Үүрэн холбооны хөрөнгө оруулалт төсөв төвлөрүүлсэн орлого /тэрбум төгрөг/..	20
Зураг 13. Үүрэн холбооны идэвхтэй хэрэглэгчийн тоо, оноор	20
Зураг 14. Хэрэглэгчийн төлбөрийн нөхцөл	21
Зураг 15. 3G, 4G/LTE хэрэглэгчийн тоо. мян	22
Зураг 16. Үүрэн холбооны бааз станцын тоо, технологийн төрлөөр	23
Зураг 17. Үүрэн холбооны 3G нэвтрэлтийн хувь, хүн амаар, 2023 он	24
Зураг 18. Үүрэн холбооны 4G/LTE нэвтрэлтийн хувь, хүн амаар, 2023 он.....	25
Зураг 19 . Үүрэн холбооны Хөдөлгөөнт өргөн зурвасын нэвтрэлтийн хувь, хүн амаар, 2023 он.....	25
Зураг 20. M2M хэрэглэгчийн тоо.....	26
Зураг 21. Ухаалаг төхөөрөмжийн төрөл.....	26
Зураг 22. Ухаалаг төхөөрөмж хэрэглэгчийн тоо	27
Зураг 23. Үүрэн холбооны сүлжээн дэх ярианы ачаалал, сая минут	27
Зураг 24. Үүрэн холбооны хэрэглэгчийн сарын мессеж болон дата хэрэглээ	28
Зураг 25. Үүрэн холбооны хэрэглэгчдийн үүсгэсэн дата хэрэглээ /ТВ/.....	29
Зураг 26. Суурин интернэт үйлчилгээний нийт орлого /тэрбум.төг/	31
Зураг 27. Интернэтийн үйлчилгээний орлогын бүтэц	32
Зураг 28. Суурин интернэт хэрэглэгчийн тоо.....	32
Зураг 29. Суурин интернэт хэрэглэгчийн тоо, байршлаар	33
Зураг 30. Суурин интернэт хэрэглэгчийн тоо, технологийн төрлөөр.....	33
Зураг 31. Суурин интернэт хэрэглэгчийн тоо, гэрээт хурдаар	34
Зураг 32. Суурин телефон үйлчилгээний нийт орлого /тэрбум.төг/.....	37
Зураг 33.Суурин телефон үйлчилгээний нэг хэрэглэгчээс олох дундаж орлого (ARPU) /төг/	37
Зураг 34. Суурин телефон холбооны орлогын бүтэц 2023 он	37
Зураг 35. Суурин холбооны идэвхтэй хэрэглэгчийн тоо.....	38
Зураг 36. Суурин холбооны ярианы ачаалал /сая минут/	39
Зураг 37. Олон суваг дамжуулах үйлчилгээний нийт орлого /тэрбум.төг/.....	41
Зураг 38. Олон суваг дамжуулах үйлчилгээний нэг хэрэглэгчээс олох дундаж орлого (ARPU) /төг/	42
Зураг 39. Олон суваг дамжуулах үйлчилгээний идэвхтэй хэрэглэгчийн тоо	42
Зураг 40. Олон суваг дамжуулах хэрэглэгчийн тоо, байршлаар	43


Зураг 41. Олон суваг дамжуулах хэрэглэгчийн тоо, байршил ба технологиор, 2023 он	43
Зураг 42. Олон суваг дамжуулах үйлчилгээний хэрэглэгч, технологийн төрлөөр	44
Зураг 43. АйПиТВ үйлчилгээний нийт хэрэглэгчийн тоо, оноор.....	44
Зураг 44 АйПиТВ хэрэглэгчийн тоо, байршлаар.....	45
Зураг 45. Телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн орлого /тэрбум төгрөг/	47
Зураг 46. Радиогийн үйлчилгээний орлого /сая төгрөг/.....	50
Зураг 47. Шуудангийн нийт үйлчилгээ эрхлэгчид болон Монгол Шуудан ХК-ийн орлогын харьцуулалт, оноор (сая төгрөг).....	54
Зураг 48. Шуудангийн үйлчилгээний орлогын бүтэц, эзлэх хувиар	54
Зураг 49. Нийт ажилтны тоо, оноор.....	57
Зураг 50. Нийт ажиллагчдын тоо, хүйсээр	58

Хавсралт

Хавсралт 1. Хэрэглэгчийн тоо, хот, аймаг бүсээр, 2023 он.....	60
Хавсралт 2. Харилцаа холбооны тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээний үндсэн үзүүлэлтүүд, сүүлийн 2 жилд.....	61
Хавсралт 3. 2023 оны жилийн эцсийн тайлангийн ирц	62

1. Танилцуулга



Харилцаа холбооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс тусгай зөвшөөрлийн гэрээ болон “Харилцаа холбооны зах зээлд шударга өрсөлдөх нөхцөл бүрдүүлэх журам”-ын 4.3-д заасны дагуу 2023 оны жилийн эцсийн тайлан мэдээллийг www.statistics.crc.gov.mn цахим системээр цуглуулан авч, мэдээллийг нэгтгэн танилцуулж байна.



2023 оны жилийн эцсийн байдлаар харилцаа холбооны үйл ажиллагаа эрхлэх **765** тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаагаас 85.75% нь зах зээлд идэвхтэй үйл ажиллагаа эрхэлж, тайлан мэдээгээ ирүүлсэн байна. Үйл ажиллагаа эхлээгүй болон тайлан, мэдээ ирүүлээгүй (165) тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн дийлэнх хувийг харилцаа холбооны сүлжээ дэд бүтцийн угсралт, суурилуулалт болон шуудан хүргэлтийн үйлчилгээ эрхлэгчид эзэлж

байна.

Харилцаа холбооны тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгчдийн **нийт орлого** 2023 оны байдлаар **2.1 их наядад** хүрсэн нь өмнөх оноос **12.8 хувиар**, төсөвт төвлөрүүлсэн орлого 363.8 орчим тэрбум төгрөг болж өмнөх оноос 12.1 хувиар тус тус өссөн. Харин нийт хөрөнгө оруулалт 338.1 орчим тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 7.8 хувиар буурсан байна.



Үүрэн холбооны нийт идэвхтэй хэрэглэгч 2023 оны жилийн эцсээр **4,841,935** болж өмнөх оноос 0.1 хувиар нэмэгдсэн бол 100 хүнд ногдох үзүүлэлт нь 138.2 болж өмнөх оноос 2.6 хувиар буурчээ.

Үүрэн холбооны идэвхтэй хэрэглэгчийн тооны өсөлт саарсан ч нийт дата хэрэглээ 28 хувиар, үйлчилгээний орлого 14.5 хувиар тус тус өссөн байна.


Үүрэн холбооны нийт хэрэглэгчийн 64.5 хувийг урьдчилсан төлбөрт, 24.7 хувийг дараа төлбөрт, 10.8 хувийг хосолсон төлбөрт хэрэглэгч эзэлж байгаа бөгөөд жил ирэх бүр үүрэн холбооны хэрэглээ дараа болон хосолсон төлбөрт үйлчилгээ руу аажим шилжиж байна.

Үүрэн холбооны зах зээлд 2022 оноос 5 оператор компани үйл ажиллагаа явуулж эхэлсэн ба 5 дахь оператор 2023 оны сүүлээс бусад сүлжээтэй харилцан холболт хийгдсэнээр хэрэглэгчийн тоо нь нэмэгдэж, зах зээлд эзлэх хувь нь 2 хувиар өсчээ. Харин давамгайллагч операторуудын зах зээлд эзлэх хувь 1-2 хувиар буурсан байна.

Үүрэн холбооны нэг хэрэглэгчээс олох дундаж орлогыг (ARPU) тооцоолоход өмнөх онд 14,372 төгрөг байсан бол 2023 оны байдлаар 16,544 төгрөг болж нэмэгджээ. Энэ нь хэрэглэгчийн тооны өсөлтийн хувь буурсан ч, үүрэн холбооны үйлчилгээнээс олж буй орлого нэмэгдсэнтэй холбоотой байна.


Үүрэн холбооны нийт дата хэрэглээ 2022 оноос 28 хувиар өссөн. Дата ачааллын хувьд 4G сүлжээн дэх ачаалал 29 хувиар нэмэгдэж 612,279 ТБайт болсон нь хэрэглэгчийн тоонд харьцуулбал нэг хэрэглэгч сард дунджаар 14.8 Гбайт дата хэрэглэсэн байна. (2022 онд энэ тоо 12.8 Гбайт байсан.)

Суурин телефон холбооны үйлчилгээний хэрэглэгч өмнөх оноос 10.3 хувиар өсч 524,075 хүрсэн байгаагаас 80 хувь нь АйПиТВ хосолсон үйлчилгээний хэрэглэгч байна. Гурвалсан үйлчилгээтэй холбоотойгоор суурин холбооны идэвхтэй хэрэглэгчийн тоо өссөн ч **190,604 хэрэглэгч буюу 36 хувь нь л суурин утсаа ашиглаж байна.** Гурвалсан үйлчилгээнээс бусад суурин холбооны үйлчилгээний хэрэглэгчийн тоо буурчээ.



Суурин телефоны ачаалал нийт дүнгээр өмнөх оноос өөрчлөлт гараагүй байна. Орох ачаалал нь 140.6 сая минут болж 2.9 хувиар өссөн бол сүлжээн доторх ачаалал 19.11 сая минут, гарах ачаалал нь 82.6 сая минут болж 13.9 болон 2.7 хувиар өмнөх оноос тус тус буурчээ. Орох, гарах ачааллын байдлаас үзвэл суурин телефон дугаараас гадагш ярих хандлага буурч, эсрэгээр суурин телефон дугаар луу залгах хандлага нэмэгдэж, хэрэглэгчийн зан төлөвт гарч буй өөрчлөлт энэ онд мөн хадгалагдаж байна.

Нийт суурин холбооны үйлчилгээний орлого 2 тэрбум болж өмнөх оноос 6.6 хувиар өсчээ.





Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчид 2023 онд хот хооронд **2612 км**, хот суурин газарт **682 км** шилэн кабелийн сүлжээ шинээр байгуулснаар **Монгол Улсын дамжуулах сүлжээний урт 51,939 км** болж өмнөх оноос 6.8 хувиар нэмэгдсэн байна.

Интернэтийн гадаад урсгалын багтаамж өмнөх оноос 20 Гбит/сек-ээр нэмэгдэж 590.5 Гбит/сек хүрсэн ба нийт 54 интернэтийн үйлчилгээ үзүүлэгч 213 Гбит/сек-ийн урсгал гэрээлсэн байна.

Улс хоорондын транзит урсгалыг багтаамж 2023 оны хагас жилээс хойш нэмэгдээгүй 1,800 Гбит/сек хэвээр байна.

Суурин интернэт хэрэглэгчийн тоо 2023 оны байдлаар **498,889**-д хүрч өмнөх оноос 14.3 хувиар өссөн байна. Үүний 471,729 (94.6%) нь өрхийн хэрэглэгч бөгөөд улсын хэмжээнд **нийт өрхийн 48 орчим хувь** нь суурин интернэтэд холбогдсон байна.

Нийт хэрэглэгчийн 76 хувь нь Улаанбаатар хотод, 24 хувь нь хөдөө орон нутагт байршилтай байна. Суурин интернэт хэрэглэгчийн тоо Улаанбаатар хотод 19, орон нутагт 2 хувиар тус тус нэмэгджээ.




Телевизийн олон суваг дамжуулах үйлчилгээний идэвхтэй хэрэглэгч 2023 онд **761,800** болж өмнөх оноос 0.2 хувиар өссөн. (Үүнд РТҮС УТҮГ болон ОТТ үйлчилгээний хэрэглэгчийн тоо ороогүй болно.) Нийт хэрэглэгчийн 98.5 хувь нь өрхийн хэрэглэгч ба Монгол Улсын нийт өрхийн тоотой харьцуулбал **77.5** хувь нь телевизийн олон суваг дамжуулах үйлчилгээг хүлээн авч үзэж байгаа нь өмнөх оноос 4.5 хувиар буурчээ.

Телевизийн олон суваг дамжуулах үйлчилгээг технологиор нь авч үзвэл хэрэглэгчийн 56.3 хувь нь АйПиТВ-ээр, 34.5 хувь нь хиймэл дагуулаар, 9.2 хувь нь кабелийн телевизээр үйлчилгээг хүлээн авч үзэж байна.

Дотоодын шуудангийн бичиг захидлын солилцоо гарах чиглэлд 9 хувиар өссөн бол орох чиглэлд 15.4 хувиар буурсан.

Нийт дүнгээр улс хоорондын шуудан солилцоо 32.1 хувиар, дотоодын шуудан солилцоо 3.5 хувиар тус тус буурчээ.

Шуудангийн үйлчилгээний орлого 40.7 тэрбум ба өмнөх оноос 16.7 хувиар буурсан байна.



2. Тусгай зөвшөөрөл


Зохицуулах хорооноос 2023 онд нийт 145 тусгай зөвшөөрөл шинээр олгож, 74 тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлж, 85 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгожээ. Хүснэгт 1-д тусгай зөвшөөрлийн шийдвэрийн талаарх мэдээллийг харуулав.

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрлийн шийдвэрийн мэдээлэл, оноор

Төрөл		2022 он	2023 он
Шинээр олгосон	Хуулийн этгээд	121	126
	Тусгай зөвшөөрөл	176	145
Нэмэлт өөрчлөлт оруулсан	Хуулийн этгээд	19	13
	Тусгай зөвшөөрөл	29	19
Сэргээсэн	Хуулийн этгээд	28	48
	Тусгай зөвшөөрөл	34	60
Сунгасан	Хуулийн этгээд	113	134
	Тусгай зөвшөөрөл	142	160
Түдгэлзүүлсэн	Хуулийн этгээд	111	54
	Тусгай зөвшөөрөл	141	74
Нэр шилжүүлсэн	Хуулийн этгээд	6	3
	Тусгай зөвшөөрөл	11	6
Хүчингүй болгосон	Хуулийн этгээд	30	71
	Тусгай зөвшөөрөл	38	85

2023 оны жилийн эцсийн байдлаар Харилцаа холбооны үйл ажиллагаа эрхлэх нийт 765, радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах 192 тусгай зөвшөөрөл, радио давтамж ашиглах 631 эрхийн бичиг олгогдсон байгаа нь өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байна. (Зураг 1)

Зураг 1. Зөвшөөрлийн тоо, оноор



Харилцаа холбооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тоог ерөнхий чиглэлээр нь авч үзвэл мэдээлэл харилцаа холбооны чиглэлээр нийт 377, өргөн нэвтрүүлгийн чиглэлээр 228, шуудангийн чиглэлээр 160 тусгай зөвшөөрөл байна. Тусгай зөвшөөрлийн тоог эрхэлж буй үйл ажиллагааны чиглэлээр нь Хүснэгт 2-т харуулсан бөгөөд харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн угсралт суурилуулалтын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл нь нийт тусгай зөвшөөрөлд 35 хувийг эзэлж байгаа нь хамгийн их байна.

Хүснэгт 2. Харилцаа холбооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тоо, төрлөөр (2023 оны жилийн эцсийн байдлаар)


Чиглэл	Тусгай зөвшөөрлийн төрөл	2021	2022	2023
Мэдээлэл харилцаа холбоо	Харилцаа холбооны сүлжээ	11	16	20
	Сансрын холбооны сүлжээ (VSAT)	6	6	7
	ХХ үйлчилгээ - суурин холбоо	8	7	7
	ХХ үйлчилгээ - үүрэн холбоо	5	5	5
	ХХ үйлчилгээ - улс хоорондын яриа	6	4	4
	ХХ үйлчилгээ - интернэт	67	61	61
	Мэдээллийн сүлжээ - контент	2	5	6
	ХХ сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт	269	264	267
	Нийт	374	368	377
Өргөн нэвтрүүлэг	РТВ газрын сүлжээ	2	2	1
	Олон суваг дамжуулах үйлчилгээ	34	31	30
	Олон нийтийн ТВ	5	5	5
	Өргөн нэвтрүүлгийн ТВ	79	65	63
	Арилжааны ТВ	59	59	51
	Төлбөртэй ТВ	11	16	20
	Олон нийтийн радио	4	4	3
	Арилжааны радио	56	58	55
Нийт	250	240	228	
Шуудан	Шуудангийн сүлжээ	8	9	12
	Дотоодын шуудангийн үйлчилгээ - Үндсэн	6	7	11
	Дотоодын шуудангийн үйлчилгээ - Нэмэлт	52	39	30
	Улс хоорондын шуудангийн үйлчилгээ - Буухиа	8	8	10
	Улс хоорондын шуудангийн үйлчилгээ - Илгээмж	64	65	97
Нийт	138	144	160	
НИЙТ		769	752	765

Жич: ХХ-Харилцаа холбооны, РТВ – Радио, Телевизийн

3. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд

Харилцаа холбооны тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгчдийн нийт орлого 2023 оны байдлаар 2.1 их наядад хүрсэн нь өмнөх оноос 12.8 хувиар, төсөвт төвлөрүүлсэн орлого 356.4 тэрбум төгрөг болж өмнөх оноос 9.9 хувиар тус тус өссөн. Харин нийт хөрөнгө оруулалт 338.1 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 7.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна. (Зураг 2.)


Зураг 2 Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, 2020-2023 он



3.1 Харилцаа холбооны үйл ажиллагааны орлого

Нийт дүнгээр харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн орлого өмнөх оноос 12.8 хувиар өсч, өсөлтийн хувь нь өмнөх жилтэй харьцуулахад 0.3 хувиар бага байна.

Зураг 3. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн орлого, оноор



Орлогыг сүүлийн 3 жилээр, үйлчилгээний төрлөөр Хүснэгт 3-т харуулав. Нийт орлогын хамгийн их буюу 56.76 хувийг үүрэн холбооны орлого бүрдүүлж байгаа нь сүүлийн 2 жилийн эзлэх хувьтай ойролцоо байна.

Өмнөх онтойгоо харьцуулахад арилжааны болон төлбөртэй телевизийн үйлчилгээний орлого 55.66 хувиар өссөн бол улс хоорондын ярианы үйлчилгээний орлого 70.69 хувиар буурчээ.

Хүснэгт 3. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн орлого, үйл ажиллагааны чиглэлээр (тэрбум төгрөг)

Салбар	Үйлчилгээний төрөл	2021		2022		2023		Өмнөх оноос өөрчлөлтийн %
		Тэрбум төгрөг	Нийт орлогод эзлэх хувь	Тэрбум төгрөг	Нийт орлогод эзлэх хувь	Тэрбум төгрөг	Нийт орлогод эзлэх хувь	
Мэдээлэл холбоо	Үүрэн холбоо	920.54	56.00%	1,039.76	55.92%	1,190.79	56.76%	14.53%
	Суурин интернэт	152.29	9.26%	172.44	9.27%	198.61	9.47%	15.18%
	Хот, хот хоорондын сүлжээ	127.15	7.74%	119.76	6.44%	160.95	7.67%	34.39%
	Улс хооронд, транзит сүлжээ	82.47	5.02%	83.57	4.49%	82.82	3.95%	-0.90%
	Сүлжээ, дэд бүтцийн угсралт, суурилуулалт	48.10	2.93%	82.83	4.45%	62.66	2.99%	-24.35%
	Суурин холбоо	25.28	1.54%	31.60	1.70%	33.68	1.61%	6.58%
	Мэдээллийн сүлжээ	11.23	0.68%	8.26	0.44%	7.46	0.36%	-9.66%
	Сансрын холбоо	-	-	8.09	0.44%	7.34	0.35%	-9.28%
	Яриа - улс хооронд	8.60	0.52%	2.36	0.13%	0.69	0.03%	-70.69%
Өргөн нэвтрүүлэг	ОСДҮ - IPTV	2.10	0.13%	117.57	6.32%	144.95	6.91%	23.29%
	ОСДҮ – Хиймэл дагуул, КаТВ	91.34	5.56%	63.69	3.43%	67.83	3.23%	6.49%
	Өргөн нэвтрүүлгийн ТВ	66.99	4.08%	55.31	2.97%	61.48	2.93%	11.16%
	Арилжааны болон төлбөртэй ТВ	44.33	2.70%	21.99	1.18%	34.23	1.63%	55.66%
	Арилжааны радио	25.37	1.54%	3.28	0.18%	3.92	0.19%	19.63%
Шуудан	Шуудангийн сүлжээ, үйлчилгээ	2.16	0.13%	48.86	2.63%	40.69	1.94%	-16.72%
Нийт		1,643.7	100%	1,859.4	100%	2,098.1	100%	12.84%

3.2 Төсөвт төвлөрүүлсэн орлого

Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн орлого өсөхийн хэрээр төсөвт төвлөрүүлж буй орлого¹ өсч ирсэн ба 2023 онд 356.4 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Зураг 4. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн төсөвт төвлөрүүлсэн орлого, оноор (тэрбум төгрөг)



Хүснэгт 4. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн төсөвт төвлөрүүлсэн орлого, үйл ажиллагааны чиглэлээр (тэрбум төгрөг)

Салбар	Үйлчилгээний төрөл	2021		2022		2023		Өмнөх оноос өөрчлөлтийн %
		Тэрбум төгрөг	Нийт орлогод эзлэх хувь	Тэрбум төгрөг	Нийт орлогод эзлэх хувь	Тэрбум төгрөг	Нийт орлогод эзлэх хувь	
Мэдээлэл холбоо	Үүрэн холбоо	187.29	62.31%	189.53	58.41%	223.22	62.63%	17.78%
	Суурин интернэт	10.78	3.59%	4.63	1.43%	9.70*	2.72%	109.60%
	Хот, хот хоорондын сүлжээ	26.23	8.73%	21.88	6.74%	25.71	7.21%	17.52%

¹ Төсөвт төвлөрүүлсэн орлого гэдэгт Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, Нийгмийн даатгалын шимтгэл, Нэмүү өртгийн албан татвар, Хувь хүний орлогын албан татвар, Гаалийн татвар, Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан болон бусад татвар, хураамж хамаардаг.

	Улс хооронд, транзит сүлжээ	4.13	1.37%	4.94	1.52%	3.82	1.07%	-22.58%
	Сүлжээ, дэд бүтцийн угсралт, суурилуулалт	5.40	1.80%	24.87	7.66%	10.44	2.93%	-58.01%
	Суурин холбоо	2.32	0.77%	0.51	0.16%	1.93*	0.54%	278.09%
	Мэдээллийн сүлжээ	3.14	1.05%	5.25	1.62%	1.61	0.45%	-69.39%
	Сансрын холбоо	0.83	0.28%	0.94	0.29%	0.67	0.19%	-29.24%
	Яриа - улс хооронд	0.1	0.06%	0.04	0.01%	0.34	0.10%	761.90%
Өргөн нэвтрүүлэг	ОСДҮ - IPTV	26.88	8.94%	35.79	11.03%	39.29	11.02%	9.78%
	ОСДҮ – Хиймэл дагуул, КаТВ	13.18	4.38%	13.01	4.01%	11.52	3.23%	-11.44%
	Өргөн нэвтрүүлгийн ТВ	8.22	2.74%	10.04	3.09%	12.74	3.58%	26.94%
	Арилжааны болон төлбөртэй ТВ	3.83	1.27%	5.76	1.78%	7.77	2.18%	34.98%
	Арилжааны радио	0.35	0.12%	0.60	0.18%	1.06	0.30%	76.12%
Шуудан	Шуудангийн сүлжээ, үйлчилгээ	7.79	2.59%	6.69	2.06%	6.60	1.85%	-1.35%
Нийт		300.56	100.00%	324.47	100.00%	356.44	100.00%	9.85%

* Гурвалсан үйлчилгээ үзүүлэгчийн төсөвт төвлөрүүлсэн орлогыг ОСДҮ үйлчилгээнд тооцсон.

3.3 Хөрөнгө оруулалт

Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн хөрөнгө оруулалтын хэмжээ сүүлийн 2 жилд өссөн бол 2023 онд өмнөх оноос 7.8 хувиар буурчээ. (зураг 5.) 2023 онд нийт 338.1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсний 79.40 хувийг үүрэн холбооны сүлжээ, үйлчилгээнд, 8.41 хувийг хот, хот хоорондын сүлжээ байгуулахад зориулсан байна. (хүснэгт 5)

Зураг 5. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн хөрөнгө оруулалтын хэмжээ, оноор



Хүснэгт 5. Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгчдийн хөрөнгө оруулалтын хэмжээ, тусгай зөвшөөрлийн төрлөөр (тэрбум төгрөг)

Салбар	Үйлчилгээний төрөл	2021		2022		2023		Өмнөх оноос өөрчлөлтийн %
		Тэрбум төгрөг	Нийт ХО-д эзлэх хувь	Тэрбум төгрөг	Нийт ХО-д эзлэх хувь	Тэрбум төгрөг	Нийт ХО-д эзлэх хувь	
Мэдээлэл холбоо	Үүрэн холбоо	172.23	61.83%	243.60	66.41%	268.41	79.40%	10.19%
	Хот, хот хоорондын сүлжээ	24.23	8.70%	42.78	11.66%	28.42	8.41%	-33.57%
	Суурин интернэт	22.78	8.18%	10.09	2.75%	2.33*	0.69%	-76.86%
	Сүлжээ, дэд бүтцийн угсралт, суурилуулалт	5.66	2.03%	6.90	1.88%	4.02	1.19%	-41.75%
	Улс хооронд, транзит сүлжээ	5.41	1.94%	6.07	1.66%	4.42	1.31%	-27.24%
	Суурин холбоо	0.95	0.34%	0.74	0.20%	*		-100.00%
	Сансрын холбоо					0.09	0.03%	
	Мэдээллийн сүлжээ					0.19	0.05%	
Өргөн нэвтрүүлэг	ОСДҮ - IPTV	33.62	12.07%	23.11	6.30%	17.34	5.13%	-24.99%
	ОСДҮ – Хиймэл дагуул, КаТВ	2.19	0.78%	2.79	0.76%	1.92	0.57%	-31.36%
	Өргөн нэвтрүүлгийн ТВ	1.57	0.56%	7.47	2.04%	3.99	1.18%	-46.64%

	Арилжааны болон төлбөртэй ТВ	0.52	0.19%	11.77	3.21%	1.22	0.36%	-89.64%
	Арилжааны радио	0.45	0.16%	0.61	0.16%	1.14	0.34%	86.40%
Шуудан	Шуудангийн сүлжээ, үйлчилгээ	6.72	2.41%	10.89	2.97%	4.60	1.36%	-57.75%
Нийт		287.54	100%	366.82	100%	338.06	100%	-7.84%

* Гурвалсан үйлчилгээ үзүүлэгчийн хөрөнгө оруулалтыг ОСДҮ үйлчилгээнд тооцсон.

ХО- Хөрөнгө оруулалт

4. Харилцаа холбооны сүлжээ

2023 оны жилийн эцсийн байдлаар Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх чиглэлээр (шуудангийн сүлжээг оруулахгүйгээр) нийт 12 хуулийн этгээд тусгай зөвшөөрөл эзэмшин үйл ажиллагаа эрхэлж байна. (хүснэгт 6)

Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх (цаашид сүлжээний гэх) тусгай зөвшөөрлийг 2023 онд улс хоорондын сүлжээ байгуулах хамрах хүрээнд 2-ыг нэмж олгосон байна.

Хүснэгт 6. Харилцаа холбооны сүлжээ байгуулах, эзэмших, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн жагсаалт, үйлчилгээний төрлөөр, 2023

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигч	Хот, хот хооронд (8)	Улс хооронд (8)	Улс хооронд-транзит (4)
1	Мэдээлэл холбооны сүлжээ ХХК			
2	Мобиком нэтворкс ХХК			
3	Жемнэт ХХК			
4	МТ Нэтворкс ХХК			
5	Айрон товер ХХК			
6	Эс Ти Би Эс ХХК			
7	Скайнэтворкс ХХК			
8	Скайстрим ХХК			
9	Ийзи гөү рөүд ХХК			
10	Ондо нэтворк ХХК			
11	Юни трансмишн нэтворк ХХК			
12	Согно телеком ХХК			

Харилцаа холбооны сүлжээний үйлчилгээ эрхлэгчид зах зээлд дараах төрлийн бөөний үйлчилгээг үзүүлж байна.

Хүснэгт 7. Харилцаа холбооны сүлжээний үйлчилгээний төрлүүд

Хот, хот хооронд	Улс хооронд/транзит
- Шилэн кабелийн шөрмөс түрээслүүлэх	- Интернэтийн бөөний урсгалын үйлчилгээ
- Тоон суваг түрээслүүлэх (Е1 суваг, дата суваг)	- Улс хоорондын транзит үйлчилгээ
- Худаг, сувагчлал түрээслүүлэх	- Улс хоорондын түрээсийн шугам

4.1 Харилцаа холбооны сүлжээний үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт

Сүлжээний тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн 2023 оны орлого 243.8 тэрбум байгаа нь өмнөх оноос 19.9 хувиар өссөн үзүүлэлт ба нийт тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйлчилгээний орлогын 11.6 хувийг эзэлж байна. Үүний 34.0 хувийг нь улс хоорондын бөөний болон транзит сүлжээний үйлчилгээний орлого бүрдүүлж байна.

Зураг 6. Харилцаа холбооны сүлжээний үйлчилгээний орлого, оноор



Улс хооронд, транзит үйлчилгээний орлого 0.9 хувиар буурсан бол Хот, хот хоорондын сүлжээний үйлчилгээний орлого өмнөх оноос 34.4 хувиар өсчээ. (хүснэгт 3)

Харин үндсэн сүлжээний хөрөнгө оруулалт нийт дүнгээр өмнөх оноос 32.8 хувиар буурсан дүнтэй байна. 2022 онд 7 компани хөрөнгө оруулалт хийсэн бол 2023 онд 8 компани хөрөнгө оруулалт хийсэн байна. Нийт хөрөнгө оруулалтын 30.6 хувийг Мэдээлэл холбооны сүлжээ ХХК, 23.4 хувийг Мобиком нэтворкс ХХК, 15.8

хувийг Юни трансмишн нэтворк ХХК, 15.4 хувийг Скайнэтворкс ХХК, 13.5 хувийг Жемнэт ХХК бүрдүүлсэн байна.

Хүснэгт 8. Харилцаа холбооны сүлжээний үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт, сүүлийн 3 жилийн өөрчлөлт

Үзүүлэлт	2021		2022		2023		Өмнөх оноос өөрчлөлтийн %
	Тэрбум төгрөг	Нийт орлогод эзлэх %	Тэрбум төгрөг	Нийт орлогод эзлэх %	Тэрбум төгрөг	Нийт орлогод эзлэх %	
Орлого	209.65	13%	203.33	11%	243.77	12%	19.89%
Төсөвт төвлөрүүлсэн орлого	30.36	10%	26.82	8%	29.54	8%	10.15%
Хөрөнгө оруулалт	29.64	6%	48.85	13%	32.83	10%	-32.79%

4.2 Харилцаа холбооны сүлжээний урт

Монгол улсын харилцаа холбооны үндсэн сүлжээ (улс, хот хоорондын сүлжээ) нь нийт 51,939 км дамжуулах сүлжээнээс бүрдэж байна. Сүлжээний уртыг тусгай зөвшөөрөл эзэмшигчээр хүснэгт 9-д харуулав.

Хүснэгт 9. Харилцаа холбооны хот, хот хоорондын дамжуулах сүлжээний урт (км), оноор

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигч	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он		
		Нийт	Нийт	Нийт	Нийт	Нийт	Хот хооронд	Хот суурин газарт
1	Жемнэт ХХК	2,265	2,265	2,265	2,265	2,265	2,265	
2	Скайнэтворкс ХХК	10,880	11,960	12,195	12,624	13,440	10,730	2,710
3	Мобиком нэтворкс ХХК*	11,685	12,572	12,895	13,064	14,597	11,889*	2,708
4	Мэдээлэл холбооны сүлжээ ХХК	18,869	19,239	19,548	19,676	20,026	19,899	127
5	МТ Нэтворкс ХХК	241	241	241	723	1,237	1,237	
6	Айрон товер ХХК	-	65	134	134	134	65	69
7	Эс ти би эс ХХК				120	120		120
8	Ондо нэтворкс ХХК				40	40		40
9	Ийзи гөү рөүд ХХК					81	29.7	51
	Нийт урт	43,940	46,342	47,278	48,644	51,939	46,114	5,825

* радио релэйний сүлжээний урт нэмэгдсэн

Харилцаа холбооны сүлжээний тусгай зөвшөөрөл эзэмшигчид 2023 онд хот хооронд **2,612** км, хот суурин газарт **682** км шилэн кабелийн сүлжээ шинээр байгуулсан байна.

Хүснэгт 10. Шилэн кабелийн сүлжээний урт (км), 2023 он

Тусгай зөвшөөрөл эзэмшигч	Хот хооронд		Хот суурин газрын сүлжээний урт	Нийт
	Сүлжээ хүрсэн чиглэл/ аймгийн тоо	урт		
Жемнэт ХХК	Урд хилээс хойд хил хүртэл	2,265		2,265
Скайнэтворкс ХХК	21 аймаг, 163 сум	10,730	2,710	13,440
Мобиком нэтворкс ХХК	21 аймаг, 139 сум	9,079	922	10,001
Мэдээлэл холбооны сүлжээ ХХК	21 аймаг, 463 сум	19,899	127	20,026
МТ Нэтворкс ХХК	4 аймгийн 8 сум*	1,237		1,237
Айрон товер ХХК	2 аймгийн 4 сум**	65	69	134
Эс Ти Би Эс ХХК	УБ хот дотор		120	120
Ондо нэтворкс ХХК	УБ-Налайх		40	40
Ийзи гөү рөүд ХХК	УБ хот дотор	29.7	51	81
Нийт урт		43,304	4,039	47,343

* МТ Нэтворкс ХХК: Дорнод (Чойбалсан – Хавиргын боомт), Говь-Алтай (Чандмань – Эрдэнэ), Сэлэнгэ (Сүхбаатар – Алтанбулаг хилийн боомт), Архангай аймгийн Цахир – Хөвсгөл аймгийн Жаргалант

** Айрон товер ХХК: Сэлэнгэ (Ерөө-Бугант), Дорнод (Гурван загал - Дашбалбар)

Зураг 7. Хот хоорондын шилэн кабелийн сүлжээний эзэмшил, 2023



Хот хоорондын шилэн кабелийн үндсэн сүлжээний 45.95 хувийг төрийн өмчийн Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн сүлжээ бүрдүүлж байгаа бол 24.78 хувийг Скайнэтворкс ХХК, 20.97 хувийг Мобиком нэтворкс ХХК-ийн байгуулсан сүлжээ тус тус бүрдүүлж байна.

4.3 Улс хоорондын сүлжээний үйлчилгээ

Монгол Улсын хэмжээнд харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд улс хоорондын сүлжээний үйлчилгээ үзүүлэгч компаниуд (хүснэгт 6) БНХАУ, ОХУ, Хонгконг, АНУ, ХБНГУ, Япон улсын компаниудаар дамжуулан Ази, Европын үндсэн порттой шууд холбогдож, интернэтийн бөөний урсгалын үйлчилгээг үзүүлж байна.

Интернэтийн гадаад урсгалын нийт багтаамж жил бүр өсч байгаа бөгөөд 2023 онд 590.5 Гбит/сек хүрч, 2022 оноос 3.5 хувиар, 2020 оноос 41.3 хувиар тус тус өссөн байна. Үүнээс интернэтийн үйлчилгээ эрхлэгчдэд түрээсэлж буй урсгалын хэмжээ 213.4 Гбит/сек-д хүрсэн нь өмнөх оноос 6.7 хувиар өссөн үзүүлэлт байна.

Зураг 8. Интернэтийн бөөний үйлчилгээ эрхлэгчдийн нийт урсгалын багтаамж: Гбит/сек



2023 оны байдлаар нийт 54 интернэтийн үйлчилгээ эрхлэгч (ISP) улс хоорондын сүлжээ эзэмшигчдээс гадаад интернэтийн урсгал түрээслэж байна.

4.4 Улс хоорондын транзит үйлчилгээ

Улс хооронд транзит урсгал түрээслүүлэх үйлчилгээг Жемнэт ХХК, Мэдээлэл холбооны сүлжээ ХХК, Мобиком нэтворкс ХХК-иуд үзүүлж, нийт 1,800 Гбит/сек урсгалыг ОХУ, БНХАУ-ын харилцаа холбооны компаниудад түрээслүүлж байна.

Түрээслүүлж буй транзит урсгалын хэмжээ өмнөх оноос 5.9 хувиар, 2020 онтой харьцуулахад 2023 онд 2.3 дахин өсчээ.

Улс хоорондын транзит урсгал түрээслүүлэх үйлчилгээний орлого 2023 онд 26.4 тэрбум төгрөг болж өмнөх оноос 8.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 11. Улс хоорондын нийт транзит урсгал ба орлогын хэмжээ, оноор


Он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
Урсгалын хэмжээ, Гбит/сек	750	780	1370	1700	1800
Орлого Тэрбум төгрөг	17.3	18.4	22.0	28.8	26.4

4.5 Сансрын холбооны сүлжээ, үйлчилгээ

Сансрын холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг 4 аж ахуйн нэгж, сансрын хөдөлгөөнт холбооны үйлчилгээг харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд 3 аж ахуйн нэгж эзэмшиж, сүлжээний түрээс, яриа, интернэтийн үйлчилгээ үзүүлж байна.

2023 онд тус үйлчилгээний орлого 7.3 тэрбум байгаа нь өмнөх оноос 0.9 хувь орчмоор буурсан үзүүлэлттэй, нийт 86 сая төгрөгийн хөрөнгө оруулалт энэ үйлчилгээнд хийгдсэн байна. (Хүснэгт 12)

Зураг 9. Сансрын холбооны үйлчилгээний орлого, оноор /тэрбум төгрөг/



Хүснэгт 12. Сансрын холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн орлого, сүүлийн 3 жилийн өөрчлөлт

Үзүүлэлт	2021		2022		2023		өөрчлөлтийн %
	Тэрбум төгрөг	Нийт орлогод эзлэх %	Тэрбум төгрөг	Нийт орлогод эзлэх %	Тэрбум төгрөг	Нийт орлогод эзлэх %	
Орлого	8.60	0.52%	8.09	0.44%	7.33	0.35%	-9.39%
Төсөвт төвлөрүүлсэн орлого	0.83	0.28%	0.94	0.29%	0.66	0.19%	-29.79%
Сансрын холбоо					0.09	0.03%	

Сансрын холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс Исатком ХХК нь тусгай зөвшөөрлийн гэрээний хүрээнд эцсийн хэрэглэгчид сансрын холбооны VSAT сүлжээгээр дамжуулан интернэт, ярианы үйлчилгээг үзүүлж байна.

2023 оны жилийн эцсийн байдлаар сансрын холбооны үйлчилгээ авч буй Исатком ХХК-ийн 366 хэрэглэгч байна. (хүснэгт 13)

Хүснэгт 13. Сансрын холбооны үйлчилгээний хэрэглэгчийн тоо

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр	2020 он	2021 он	2022 он	2023 он
1	Исатком ХХК	438	438	366	366

5. Үүрэн холбооны үйлчилгээ

Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд үүрэн холбооны яриа, мессеж болон интернэт үйлчилгээг 5 компани үзүүлж байна. 2023 онд тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээ эрхлэгчдийн нийт орлогын 56.76 хувь, хөрөнгө оруулалтын 79.40 хувийг үүрэн холбооны компаниуд бүрдүүлжээ.

Монгол Улс үүрэн холбооны үйлчилгээний 3G технологийг 2008 онд, 4G технологийг 2016 онд тус тус зах зээлд нэвтрүүлж байсан бол 2022 онд 5G технологийн туршилтыг хийж эхлүүлээд байна.

Үүрэн холбооны зах зээлд 2022 оноос 5 оператор компани үйл ажиллагаа явуулж эхэлсэн ба 5 дахь оператор 2023 оны сүүлээс бусад сүлжээтэй харилцан холболт хийснээр хэрэглэгчийн тоо нь нэмэгдэж, зах зээлд эзлэх хувь нь 2 хувиар өсчээ. Харин давамгайлалч операторуудын зах зээлд эзлэх хувь 1-2 хувиар буурсан байна. (хүснэгт 14)


Хүснэгт 14. Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчдийн зах зээлд эзлэх хувь

Тусгай зөвшөөрөл эзэмшигч	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
Мобиком корпораци ХХК	38.64%	37.80%	38.03%	38.17%	38.30%	37.95%	36.85%
Скайтел ХХК	15.25%	16.51%	17.43%	18.06%	17.65%	17.50%	18.62%
Юнител ХХК	35.16%	34.03%	33.08%	32.20%	34.34%	34.04%	32.24%
Жи-Мобайл ХХК	10.95%	11.66%	11.46%	11.58%	9.71%	9.66%	9.49%
Ондо ХХК						0.85%	2.80%

5.1 Үүрэн холбооны үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт

Үүрэн холбооны үйлчилгээний орлого 2015 оноос 2023 он хүртэл тогтмол өссөн бөгөөд дундаж өсөлт нь 11.34 хувь байна. 2023 оны жилийн эцсийн байдлаар үүрэн холбооны орлого 1.1 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оноос 14.53 хувиар өсчээ.

Зураг 10. Үүрэн холбооны нийт орлого /тэрбум.төг/



Хүснэгт 15. Үүрэн холбооны үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт, сүүлийн 3 жилийн өөрчлөлт

Үзүүлэлт	2021		2022		2023		Сүүлийн жилийн өөрчлөлтийн %
	Тэрбум төгрөг	Нийт дүнд эзлэх %	Тэрбум төгрөг	Нийт дүнд эзлэх %	Тэрбум төгрөг	Нийт дүнд эзлэх %	
Орлого	920.54	56.00%	1,039.76	55.92%	1,190.78	56.76%	14.52%
Төсөвт төвлөрүүлсэн орлого	187.29	62.31%	189.53	58.41%	223.22	62.63%	17.78%
Хөрөнгө оруулалт	172.23	61.83%	243.60	66.41%	268.41	79.40%	10.18%


2007 онд үүрэн холбооны үндсэн үйлчилгээний орлогын 90 орчим хувийг ярианы үйлчилгээ дангаар эзэлж байсан бол 2008 оноос хойш өндөр хурдны 3G үйлчилгээ, 2016 онд LTE үйлчилгээ нэвтэрснээс хойш хэрэглэгчийн хандлага ярианаас дата үйлчилгээ рүү шилжиж, жилээс жилд ярианы үйлчилгээний орлого буурч, дата үйлчилгээний орлого өсч байна. Хүснэгт 16-аас харахад 2022 онд нийт орлогын 35.35 хувийг ярианы үйлчилгээ, 31.26 хувийг дата үйлчилгээ эзэлж байсан бол 2023 онд нийт орлогын 42.98 хувийг дата үйлчилгээний орлого, 24.35 хувийг ярианы үйлчилгээний орлого эзэлж байна. Дата үйлчилгээний орлогыг 2017 онтой харьцуулахад 6.3 дахин өссөн байна.

Хүснэгт 16. Үүрэн холбооны үндсэн үйлчилгээний орлогын бүтэц

Орлогын бүтцээр	Орлогын бүтэц, %						
	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
Яриа	47.70%	38.70%	37.55%	36.67%	34.29%	35.35%	24.35%
Дата үйлчилгээ	14.90%	21.60%	25.00%	28.27%	32.35%	31.26%	42.98%
Богино үсэгт мэдээ	5.54%	6.71%	4.10%	3.85%	3.35%	3.79%	3.18%
Харилцан холболт	9.02%	7.89%	7.08%	7.20%	6.90%	6.15%	5.40%
Дамжуулан холболт	0.58%	0.01%	0.01%	0.02%	0.02%	0.01%	0.01%
Улс хоорондын үйлчилгээ	0.86%	1.25%	0.72%	0.49%	0.50%	0.53%	0.98%
Нэмэлт үйлчилгээ	5.70%	4.32%	4.26%	5.01%	4.61%	3.96%	3.53%
Улс хоорондын роуминг	1.09%	0.99%	1.10%	0.18%	0.12%	0.28%	0.72%
Гар утас,модем	11.12%	12.42%	13.52%	11.06%	11.51%	11.97%	12.63%
Бусад	3.50%	6.11%	6.65%	7.26%	6.35%	6.69%	6.21%
НИЙТ	100.00%	100.00%	100.00%	100.00%	100.00%	100.00%	100.00%

Үүрэн холбооны нэг хэрэглэгчээс олох дундаж орлогыг (ARPU) тооцоолоход өмнөх онд 14,372 төгрөг байсан бол 2023 оны байдлаар 16,544 төгрөг болж өмнөх оноос 4.8 хувиар өссөн байна.

Зураг 11. Үүрэн холбооны нэг хэрэглэгчээс олох дундаж орлого (ARPU) /төг/



Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчид 2023 онд 268.4 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийсэн нь өмнөх оноос 10.18 хувиар, 223.2 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн нь өмнөх оноос 17.77 хувиар тус тус өссөн байна.

Зураг 12. Үүрэн холбооны хөрөнгө оруулалт төсөв төвлөрүүлсэн орлого /тэрбум төгрөг/




5.2 Үүрэн холбооны хэрэглэгчийн тоо

2023 оны жилийн эцсийн байдлаар нийт үүрэн холбооны идэвхтэй хэрэглэгчийн тоо нь давхардсан тоогоор 4,841,935 болж өмнөх оноос 0.1 хувиар нэмэгдсэн бол 100 хүнд ногдох үзүүлэлт нь 138.2 болж өмнөх оноос 2.6 хувиар буурлаа. (зураг 13)

Энэ үзүүлэлт нь дэлхийн орнуудын дундажтай харьцуулахад Монгол Улсын хувьд харьцангуй өндөр үзүүлэлт юм. (хүснэгт 17)

Зураг 13. Үүрэн холбооны идэвхтэй хэрэглэгчийн тоо, оноор




Хүснэгт 17. Үүрэн холбооны нэвтрэлтийн түвшин

	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023
Дэлхийн дундаж	97	101	103	105	106	105	106	108	110.6
Монгол улс	103.5	111.2	125.5	133.4	136.7	132.5	137.0	141.8	138.2

Эх сурвалж: ИТУ

Үүрэн холбооны нийт хэрэглэгчийн 64.5 хувийг урьдчилсан төлбөрт, 24.7 хувийг дараа төлбөрт, 10.8 хувийг хосолсон төлбөрт хэрэглэгч эзэлж байна. Жил ирэх бүр үүрэн холбооны хэрэглээ дараа болон хосолсон төлбөрт хэлбэрт шилжих хандлагатай байгаа нь зураг 14-өөс харагдаж байна.

Зураг 14. Хэрэглэгчийн төлбөрийн нөхцөл



Үүрэн холбооны сүлжээнд нийт 4.1 сая хэрэглэгч интернэт хэрэглэж байгаа нь өмнөх оноос 3.1 хувиар өссөн байна. Тус хөдөлгөөнт өргөн зурвасын хэрэглэгчийн 9 хувийг дата (only data) хэрэглэгч эзэлж байгаа нь өмнөх жилээс 5.4 хувиар өсчээ.


Хүснэгт 18. Хөдөлгөөнт өргөн зурвасын хэрэглэгчийн тоо

Он	Дата ба яриа хосолсон	Зөвхөн дата Only data	Нийт
2018	3,325,317	95,239	3,420,556
2019	3,351,665	252,686	3,604,351
2020	3,353,188	226,583	3,579,771
2021	3,633,268	255,971	3,889,239
2022	3,644,821	352,079	3,996,900
2023	3,751,283	371,083	4,122,366

Үүрэн холбооны 3G сүлжээ Монгол Улсын 345 сум, суурин газарт нэвтэрч, нийт хүн амын 100 хувийг хамарсан бөгөөд 3G хэрэглэгчийн тоо 2023 оны жилийн эцсийн байдлаар 3.5 саяд хүрч, 2022 онтой харьцуулахад 0.44 хувийн өсөлттэй байна.

Харин 4G/LTE сүлжээ нийт хүн амын 99 хувийг хамарч, үйлчилгээний хэрэглэгчийн тоо 3.4 саяд хүрч, өмнөх оноос 11.4 хувиар өссөн.

Зураг 15. 3G, 4G/LTE хэрэглэгчийн тоо. мян




Үүрэн холбооны сүлжээ жил ирэх бүр хүрээгээ тэлж нийт дүнгээр өмнөх оноос 27.83 хувиар нэмэгджээ. Нийт бааз станцын 56.88 хувийг 4G сүлжээний, 23.19 хувийг 3G сүлжээний, 19.94 хувийг 2G сүлжээний бааз станц бүрдүүлж байна. Бааз станцын тоог технологийн төрлөөр хүснэгт 19, зураг 16-д харуулав.

Хүснэгт 19. Үүрэн холбооны бааз станцын тоо, технологийн төрлөөр

	2G	3G	4G	Нийт
2019	2,031	2,225	2,454	6,710
2020	2,480	2,691	3,656	8,827
2021	2,734	2,980	4,344	10,058
2022	2,753	3,128	5,769	11,650
2023	2,969 (19.94%)	3,453 (23.19%)	8,471 (56.88%)	14,893 (100%)

Зураг 16. Үүрэн холбооны бааз станцын тоо, технологийн төрлөөр




Үүрэн холбооны нийт хэрэглэгч болон 3G, 4G/LTE хэрэглэгчийн тоог Улаанбаатар хот, аймаг, бүс нутгийн хүн амын тоотой харьцуулахад 4G/LTE хэрэглэгчийн нэвтрэлт баруун бүсэд хамгийн бага буюу 65.4 хувьтай байгаа бол Улаанбаатар хотод 105.6 хувьд хүрсэн ба үүнийг аймаг тус бүрээр дэлгэрэнгүй байдлаар хүснэгт 20-д, мөн зураг 17, 18, 19-д тус тус харуулав.

Хүснэгт 20. Үүрэн холбооны хэрэглэгчдийн тоо бүс, байршлаар, 2023 он


Байршлаар	Хүн ам	Үүрэн холбоо	3G	4G/LTE	Хөдөлгөөнт өргөн зурвас
НИЙТ	3,504,741	4,841,935	3,575,115	3,447,287	4,122,366
		138.15%	102.01%	98.36%	117.62%
БАРУУН БҮС	419,864	467,887	290,283	288,606	366,395
БАЯН-ӨЛГИЙ	116,615	106,148	67,201	72,729	86,590
ГОВЬ-АЛТАЙ	56,752	71,102	43,723	42,539	56,066
ЗАВХАН	71,126	94,118	52,636	47,197	66,932
УВС	83,914	93,791	58,769	60,569	75,713
ХОВД	91,457	102,728	67,954	65,572	81,094
ХАНГАЙН БҮС	602,959	676,070	453,743	434,496	534,651
АРХАНГАЙ	92,343	103,556	60,577	63,529	73,307
БАЯНХОНГОР	88,166	97,300	62,123	59,625	76,435
БУЛГАН	60,535	63,659	44,622	42,986	54,278
ОРХОН	110,440	121,215	100,732	96,764	114,170
ӨВӨРХАНГАЙ	114,630	121,326	90,521	77,128	97,088

ХӨВСГӨЛ	136,845	169,014	95,168	94,464	119,373
ТӨВИЙН БҮС	518,227	714,787	605,616	541,262	653,904
ГОВЬСҮМБЭР	18,042	21,328	17,242	15,947	20,030
ДАРХАН -УУЛ	109,236	126,967	99,440	96,425	119,275
ДОРНОГОВЬ	71,517	107,393	94,285	79,689	103,521
ДУНДГОВЬ	46,092	56,045	38,115	32,608	42,408
ӨМНӨГОВЬ	75,198	169,525	136,681	139,342	163,101
СЭЛЭНГЭ	106,691	117,434	107,154	93,993	110,295
ТӨВ	91,451	116,095	112,699	83,258	95,274
ЗҮҮН БҮС	228,843	303,324	205,589	183,311	243,728
ДОРНОД	84,053	102,660	77,993	71,024	87,449
СҮХБААТАР	65,696	83,747	49,815	52,439	69,695
ХЭНТИЙ	79,094	116,917	77,781	59,848	86,584
УЛААНБААТАР	1,734,848	2,679,867	2,019,884	1,999,612	2,323,688
		154.47%	116.43%	115.26%	133.94%


Зураг 17. Үүрэн холбооны 3G нэвтрэлтийн хувь, хүн амаар, 2023 он



Зураг 18. Үүрэн холбооны 4G/LTE нэвтрэлтийн хувь, хүн амаар, 2023 он.




Зураг 19. Үүрэн холбооны Хөдөлгөөнт өргөн зурвасын нэвтрэлтийн хувь, хүн амаар, 2023 он.



Үүрэн холбооны сүлжээн дэх машин буюу төхөөрөмжийн (M2M) тоо 166,595 болсон нь өмнөх оноос 18.4 хувиар буурсан байна.


Зураг 20. M2M хэрэглэгчийн тоо




“M2M хэрэглэгч” гэж машин буюу төхөөрөмж хооронд (автомашины GPS, ТҮЦ машин, төлбөр тооцооны PoS машин, камер, ухаалаг тоолуур, гэрийн ухаалаг төхөөрөмжүүд гм), хүний оролцоогүйгээр өрөгдөл дамжуулах зорилгоор ашиглаж буй сим карт буюу хэрэглэгчийн тоо юм. M2M мобайл сүлжээ хэрэглэгч нь ямар нэг хувь хүнд хамаарахгүй, тухайн төхөөрөмжийг хэд хэдэн хүн ашиглах боломжтой байдгаараа онцлогтой.

Ухаалаг төхөөрөмж хэрэглэгчийн тоо 2023 оны жилийн эцсийн байдлаар 4,087,212-д хүрч өмнөх оноос 1.77 хувиар өссөн байна. Хэрэглэгчийн ухаалаг төхөөрөмжийн 64.3 хувийг Андроид, 32.7 хувийг Apple IOS үйлдлийн систем бүхий төхөөрөмж эзэлж байгаа бөгөөд Apple IOS төхөөрөмжийн хэрэглээ өмнөх оноос 25.2 хувиар өсчээ.

Зураг 21. Ухаалаг төхөөрөмжийн төрөл



Зураг 22. Ухаалаг төхөөрөмж хэрэглэгчийн тоо




5.3 Үүрэн холбооны ачаалал/хэрэглээ

5.3.1 Ярианы ачаалал

Үүрэн сүлжээ доторх ачааллыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.82 хувиар, гарах ярианы ачаалал 2.20 хувиар тус тус өссөн, харин орох ачаалал 6.78 хувиар буурсан байна.

Зураг 23. Үүрэн холбооны сүлжээн дэх ярианы ачаалал, сая минут



Үүрэн холбооны ярианы ачааллын дийлэнх хувийг сүлжээн доторх яриа эзэлдэг нь сүлжээндээ үнэгүй ярих үйлчилгээг оператор бүр үзүүлдэгтэй холбоотой

байдаг. Гэхдээ бусад сүлжээнд ярих ачаалал сүүлийн жилүүдэд бага зэрэг өсөх хандлагатай байна.


Үүрэн сүлжээн дэх ярианы нийт ачааллыг хэрэглэгчийн тоотой харьцуулж тооцоолоход үүрэн холбооны нэг хэрэглэгч хоногт дунджаар 7.1 минутын ярианы ачаалал үүсгэсэн байна.

5.3.2 Мессеж ба дата хэрэглээ

2023 оны жилийн эцсийн байдлаар үүрэн холбооны нэг хэрэглэгч сард дунджаар 12.9 ширхэг мессежийг илгээсэн бөгөөд нийт дүнгээрээ 2017 оны хэрэглээнээс 4.07 дахин буурчээ.


Харин 4G сүлжээнд үүсгэсэн нэг хэрэглэгчийн дата хэрэглээ жил бүр өсөлттэй байгаа бөгөөд 2021 онд 10.58 гигабайт, 2022 онд 12.78 гигабайт, 2023 онд 14.80 гигабайтад хүрсэн байна. Тухайн хэрэглээг нийт дүнгээр нь авч үзвэл 612,279 терабайт хүрсэн нь 2020 оноос 2,9 дахин нэмэгджээ.

Зураг 24. Үүрэн холбооны хэрэглэгчийн сарын мессеж болон дата хэрэглээ



Үүрэн холбооны хэрэглэгчдийн үүсгэсэн дата хэрэглээ 2023 оны жилийн эцсийн байдлаар 612,279 Терабайтад хүрч, дата хэрэглээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 29.01 хувиар өссөн байна.

Зураг 25. Үүрэн холбооны хэрэглэгчдийн үүсгэсэн дата хэрэглээ /ТВ/



Хүснэгт 21. Үүрэн холбооны үйлчилгээний нэг хэрэглэгчийн сарын дундаж дата хэрэглээ

ОН	3G хэрэглэгч	Дата хэрэглээ нийт /GB/	Нэг хэрэглэгчийн 1 сарын дундаж хэрэглээ /GB/	4G хэрэглэгч	Дата хэрэглээ нийт /GB/	Нэг хэрэглэгчийн 1 сарын дундаж хэрэглээ /GB/
2018	2,515,800	34,157,518	1.1	1,473,300	34,578,336	2
2019	3,190,500	43,010,021	1.1	1,956,800	102,903,673	4.4
2020	3,294,300	50,291,174	1.3	2,365,100	212,004,218	7.5
2021	3,539,362	48,883,129	1.2	2,809,592	356,579,612	10.58
2022	3,559,582	41,425,077	1.0	3,093,666	474,596,487	12.78
2023	3,575,115	49,116,903	1.1	3,447,287	612,278,731	14.80

Үүрэн холбооны үйлчилгээ эрхлэгчид LTE сүлжээнд смарт бокс ашигласан “Гэр”, “Манай”, “Скайнэт” зэрэг интернэт үйлчилгээг санал болгож буй бөгөөд тэдгээр хэрэглэгчийн тоо 2023 оны байдлаар 135,223 байгаа нь өмнөх оноос бага зэрэг буурсан байна.

Хүснэгт 22. Хөдөлгөөнт өргөн зурвасын смарт бокс ашиглан үйлчилгээ авч буй хэрэглэгчийн тоо

	2018	2019	2020	2021	2022	2023
Хөдөлгөөнт өргөн зурвас LTE/Wimax Смарт бокс хэрэглэгч	101,959	102,185	114,602	136,030	133,851	135,223

6. Суурин интернэт үйлчилгээ

Суурин интернэтийн үйлчилгээ эрхэлж буй 61 тусгай зөвшөөрөл эзэмшигч (ISP) байгаагаас 27 нь Монгол Улс, 16 нь Улаанбаатар, 18 нь аймаг сумын хамрах хүрээ бүхий тусгай зөвшөөрөлтэй байна. 2023 онд шинээр 1 интернэтийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон бол 2 тусгай зөвшөөрлийг сэргээж, 2 тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон байна.

Идэвхтэй гэрээт хэрэглэгчийн тоогоор зах зээлд эзлэх хувийг нийт Монгол Улс, Улаанбаатар хот болон орон нутагт гэж тооцвол ТОП 6 компани нийт зах зээлийн 99 орчим хувийг дангаар бүрдүүлж байна. (хүснэгт 23)

АйПиТВ үйлчилгээ үзүүлэгч 2 компанийн зах зээлд эзлэх хувь өндөр байгаагаас харвал хэрэглэгч интернэтийг дангаар бус телевиз, контентийн үйлчилгээтэй хослуулан хэрэглэх хандлага өндөр байгааг илэрхийлж байна.

Хүснэгт 23. Суурин интернэтийн үйлчилгээ эрхлэгчийн зах зээлд эзлэх хувь, идэвхтэй хэрэглэгчийн тоогоор

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигч	Монгол Улс		Улаанбаатар		Орон нутаг	
		Тоо	Эзлэх хувь	Тоо	Эзлэх хувь	Тоо	Эзлэх хувь
1	Юнивишн ХХК	384,027	76.98%	293,881	77.48%	90,146	75.39%
2	Скаймедиа корпораци ХХК	53,573	10.74%	46,080	12.15%	7,493	6.27%
3	Мобинет ХХК	24,308	4.87%	15,302	4.03%	9,006	7.53%
4	Эн Би Си ХХК	9,530	1.91%	8,780	2.31%	750	0.63%
5	Монголын цахилгаан холбоо ХК	16,210	3.25%	5,901	1.56%	10,309	8.62%
6	Кевико ХХК	7,548	1.51%	7,320	1.93%	228	0.19%
	Нийт		99.3%		99.5%		98.6%

6.1 Суурин интернэт үйлчилгээний орлого

Суурин интернэт үйлчилгээний орлого 2023 онд өмнөх оноос 15.18 хувиар өсч 198.6 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт харилцаа холбооны үйлчилгээний орлогын

9.47 хувийг эзэлж байна. Төсөвт төвлөрүүлсэн орлого 9.7 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оноос 2 дахин өссөн үзүүлэлт байна.


Хүснэгт 24. Суурин интернэт үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт, сүүлийн 3 жилийн өөрчлөлт

Үзүүлэлт	2021		2022		2023		өөрчлөлтийн %
	Тэрбум төгрөг	Нийт орлогод эзлэх %	Тэрбум төгрөг	Нийт орлогод эзлэх %	Тэрбум төгрөг	Нийт орлогод эзлэх %	
Орлого	152.29	9.26%	172.44	9.27%	198.61	9.47%	15.18%
Төсөвт төвлөрүүлсэн орлого	10.78	3.59%	4.63	1.43%	9.70	2.72%	109.5%
Хөрөнгө оруулалт	22.78	8.18%	10.09	2.75%	2.33	0.69%	-76.91%

2023 онд нийт 6 компани суурин интернэтийн үйлчилгээнд хөрөнгө оруулалт хийсэн нь 2.3 тэрбум төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 5 дахин буурчээ.


(Жич: Хөрөнгө оруулалтын дүн нь интернэтийн үйлчилгээг дангаар үзүүлдэг компаниудын дүн ба гурвалсан үйлчилгээ үзүүлж буй компаниудын хөрөнгө оруулалтыг олон суваг дамжуулах үйлчилгээнд оруулж тооцсон болно.)

Зураг 26. Суурин интернэт үйлчилгээний нийт орлого /тэрбум.төг/



Суурин интернэт үйлчилгээний нийт орлогын 54.27 хувийг өрх, 6.11 хувийг төсвийн байгууллага, 37.50 хувийг аж ахуйн нэгж байгууллагын хэрэглэгчээс бүрдүүлж байна.


Зураг 27. Интернэтийн үйлчилгээний орлогын бүтэц



6.2 Суурин интернэт хэрэглэгчийн тоо

Монгол Улсын хэмжээнд суурин интернэтэд холбогдсон буюу гэрээт хэрэглэгчийн тоо 2023 оны жилийн эцсийн байдлаар 62,442 -оор нэмэгдэн 498,889-д хүрч өмнөх оноос 14.3 хувиар өсчээ. Үүний 471,729 нь өрхийн хэрэглэгч бөгөөд улсын хэмжээнд нийт өрхийн 48 орчим хувь нь суурин интернэтэд холбогдсон нь өмнөх оноос 3.2 хувиар өсчээ. 100 хүнд ногдох үзүүлэлтээр тооцвол 14.2 хувьд хүрсэн байна.


Зураг 28. Суурин интернэт хэрэглэгчийн тоо



Суурин интернэт хэрэглэгчийг байршлаар нь авч үзвэл 76.03 хувь нь Улаанбаатар хотод, 23.97 хувь нь орон нутагт байна.


Нийт өрхийн тоотой харьцуулбал Улаанбаатар хотод суурин интернэтийн нэвтрэлт 81.56 хувь, харин орон нутагт дунджаар 23.06 хувьтай байна.

Зураг 29. Суурин интернэт хэрэглэгчийн тоо, байршлаар




Суурин интернэт хэрэглэгчийн 96.1 хувь нь өндөр хурдны шилэн кабелийн сүлжээ, үлдсэн 3.9 хувь нь Wi-Fi, Wi-MAX, DSL -ийн холболттой байна. 2020 онд гэрээт интернэт хэрэглэгчийн тоо буурсан бол 2021, 2022, 2023 онуудад өсч, шилэн кабелиар холбогдсон хэрэглэгчийн тоо 2023 онд 15.7 хувиар нэмэгджээ.

Зураг 30. Суурин интернэт хэрэглэгчийн тоо, технологийн төрлөөр



2023 оны тоон мэдээллээр нийт хэрэглэгчийн 86.9 хувь нь 10 Мбит/сек-ээс дээш хурдаар үйлчилгээ авч байна.

Зураг 31. Суурин интернэт хэрэглэгчийн тоо, гэрээт хурдаар



Нийт интернэтийн хэрэглэгчийн 94.6 хувь нь өрхийн хэрэглэгч бөгөөд улсын хэмжээнд өрхийн тоотой харьцуулбал нэвтрэлт 47.9 хувь, Улаанбаатар хотод 77.2 хувь, аймгуудаас хамгийн өндөр нь Орхон аймаг 67.7 хувьтай, харин хамгийн бага нь Завхан аймаг 7.6 хувьтай байна.

Хүснэгт 25. Суурин интернэт хэрэглэгчийн тоо, хот, аймаг бүсээр

Аймаг, хот	Хэрэглэгчийн тоо			Өрхийн тоо*	Өрхийн нэвтрэлт
	Нийт	Байгууллагын	Өрхийн		
НИЙТ	498,889	27,160	471,729	983,485	47.97%
УЛААНБААТАР	379,317	20,247	359,070	465,059	77.21%
БАРУУН БҮС	16,123	1,204	14,919	111,637	13.36%
БАЯН-ӨЛГИЙ	2,811	251	2,560	26,329	9.72%
ГОВЬ-АЛТАЙ	3,082	200	2,882	16,430	17.54%
ЗАВХАН	1,856	205	1,651	21,710	7.60%
УВС	3,646	262	3,384	22,950	14.75%
ХОВД	4,728	286	4,442	24,218	18.34%
ХАНГАЙН БҮС	41,423	2,020	39,403	179,321	21.97%
АРХАНГАЙ	3,046	197	2,849	28,257	10.08%
БАЯНХОНГОР	5,198	257	4,941	27,101	18.23%
БУЛГАН	2,129	305	1,824	19,328	9.44%
ОРХОН	21,009	690	20,319	30,005	67.72%
ӨВӨРХАНГАЙ	3,732	290	3,442	34,448	9.99%
ХӨВСГӨЛ	6,309	281	6,028	40,182	15.00%

ТӨВИЙН БҮС	47,602	2,939	44,663	156,784	28.49%
ГОВЬСҮМБЭР	2,379	129	2,250	5,390	41.74%
ДАРХАН -УУЛ	16,579	624	15,955	30,434	52.42%
ДОРНОГОВЬ	7,651	491	7,160	21,543	33.24%
ДУНДГОВЬ	1,974	164	1,810	14,875	12.17%
ӨМНӨГОВЬ	8,385	777	7,608	25,336	30.03%
СЭЛЭНГЭ	6,861	396	6,465	30,361	21.29%
ТӨВ	3,773	358	3,415	28,845	11.84%
ЗҮҮН БҮС	14,424	750	13,674	70,684	19.35%
ДОРНОД	7,955	312	7,643	25,347	30.15%
СҮХБААТАР	2,394	195	2,199	19,481	11.29%
ХЭНТИЙ	4,075	243	3,832	25,856	14.82%

**Эх сурвалж: 2023 оны байдлаар өрхийн тоог 1212.тн*

6.3 Суурин интернэтийн хэрэглээ

Нийт суурин интернэт хэрэглэгчийн тоо болон нийт хэрэглээнд харьцуулалт хийхэд нэг хэрэглэгч дунджаар сард 176.2 Гбит/сек интернэт хэрэглэж байна.

Хүснэгт 26. Суурин интернэт үйлчилгээний нэг хэрэглэгчийн сарын дундаж хэрэглээ

Огноо	Суурин интернэт хэрэглэгч	Дата хэрэглээ нийт /GB/	Нэг хэрэглэгчийн сарын дундаж хэрэглээ /GB/
2018 ОН	306,150	205,564,414	56
2019 ОН	317,317	279,347,965	73.4
2020 ОН	307,166	529,136,120	143.6
2021 ОН	379,727	672,012,475	147.5
2022 ОН	436,447	787,179,980	150.3
2023 ОН	498,889	1,055,021,930	176.2

7. Суурин телефон үйлчилгээ

Харилцаа холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд нийт 7 аж ахуйн нэгж суурин холбооны ярианы үйлчилгээг цахилгаан холбооны уламжлалт (PSTN), дараа үеийн (NGN), интернэт протоколд суурилсан (VoIP) болон интернэтэд суурилсан (OTT) технологиуд ашиглан үзүүлж байна.

Суурин телефон үйлчилгээний идэвхтэй хэрэглэгчийн тоог ОУЦХБ-ын аргачлалын дагуу сүүлийн 3 сард төлбөр төлсөн хэрэглэгчээр тооцож, зах зээлд эзлэх хувийг тооцвол Юнивишн ХХК нийт дүнгээр буюу Монгол Улсын хэмжээнд

70.81 хувь, Улаанбаатар хотод 69.97 хувь, орон нутаг 74.48 хувийг тус тус эзэлж байна.

Юнивишн болон Скаймедиа үйлчилгээний хэрэглэгчдийн хувьд дийлэнх хувь нь гурвалсан үйлчилгээний хэрэглэгчид эзэлж байгаа бөгөөд гурвалсан үйлчилгээний хүрээнд төлбөр төлснөөр ярианы үйлчилгээний хэрэглэгчээр тооцсон болно.

Хүснэгт 27. Суурин телефон үйлчилгээ эрхлэгчийн зах зээлд эзлэх хувь, идэвхтэй хэрэглэгчийн тоогоор, 2023 он

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигч	Монгол Улс		Улаанбаатар		Орон нутаг	
		Тоо	Эзлэх хувь	Тоо	Эзлэх хувь	Тоо	Эзлэх хувь
1	Юнивишн ХХК	371,100	70.81%	298,304	69.97%	72,796	74.48%
2	Скаймедиа корпораци ХХК	49,315	9.41%	46,684	10.95%	2,631	2.69%
3	МЦХ ХК	39,584	7.55%	25,626	6.01%	13,958	14.28%
4	Онлайн нетворк ХХК	38,389	7.33%	38,389	9.00%		0.00%
5	Мобинет ХХК	17,149	3.27%	11,093	2.60%	6,056	6.20%
6	УБТЗ ХНН	4,551	0.87%	2,248	0.53%	2,303	2.36%
7	Жи мобайлнэт ХХК	3,987	0.76%	3,987	0.94%		0.00%
Нийт		524,075	100.00%	426,331	100.00%	97,744	100.00%


7.1 Суурин телефон үйлчилгээний орлого

Суурин телефон үйлчилгээний орлого 2023 онд өмнөх оноос 6.56 хувиар нэмэгдэж, 33.68 тэрбум төгрөг байгаа нь нийт орлогын 1.61 хувийг эзэлж байна. Харин төсөвт төвлөрүүлсэн орлого 3.8 дахин өссөн бол хөрөнгө оруулалт хийгдээгүй байна. (Жич: Гурвалсан үйлчилгээ үзүүлж буй компаниудын хөрөнгө оруулалтыг олон суваг дамжуулах үйлчилгээнд оруулж тооцсон болно.)

Хүснэгт 28. Суурин телефон үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт, сүүлийн 3 жилийн өөрчлөлт


Үзүүлэлт	2021		2022		2023		Өмнөх оноос өөрчлөлтийн %
	Тэрбум төгрөг	Нийт орлогод эзлэх %	Тэрбум төгрөг	Нийт орлогод эзлэх %	Тэрбум төгрөг	Нийт орлогод эзлэх %	
Орлого	25.28	1.54%	31.60	1.70%	33.68	1.61%	6.59%
Төсөвт төвлөрүүлсэн орлого	2.32	0.77%	0.51	0.16%	1.92	0.54%	280.7%
Хөрөнгө оруулалт	0.95	0.34%	0.74	0.20%	0	0.00%	-100.0%

Зураг 32. Суурин телефон үйлчилгээний нийт орлого /тэрбум.төг/




Суурин телефон холбооны нэг хэрэглэгчээс нэг сард олох дундаж орлогыг (ARPU) тооцоолоход 2023 онд 5,356 төгрөг байгаа нь өмнөх оноос 3.3 хувиар буурсан байна.

Зураг 33. Суурин телефон үйлчилгээний нэг хэрэглэгчээс олох дундаж орлого (ARPU) /төг/



Суурин телефон холбооны орлогын бүтцээс харахад нийт орлогын 91.01 хувь нь ярианы үйлчилгээнээс, 8.73 хувь нь харилцан холболтын үйлчилгээнээс, 0.25 хувь нь нэмэлт үйлчилгээнээс олсон орлого байна.


Зураг 34. Суурин телефон холбооны орлогын бүтэц 2023 он



7.2 Суурин телефон хэрэглэгчийн тоо

Суурин телефон үйлчилгээний 524,075 хэрэглэгч байгаагаас 80.2 хувь нь АйПиТВ хосолсон үйлчилгээний хэрэглэгч байна. Сүлжээнд сүүлийн 3 сар ярианы ачаалал үүсгэсэн (дугаар дээрээс яриа хийсэн эсхүл хүлээн авсан) байдлаар авч үзвэл 190,604 хэрэглэгч өөрийн суурин холбооны үйлчилгээний дугаараа сүлжээнд идэвхтэй ашиглаж байна.

Зураг 35. Суурин холбооны идэвхтэй хэрэглэгчийн тоо



Хосолсон үйлчилгээний хэрэглэгчид хэдийгээр суурин телефон үйлчилгээний сүлжээнд холбогдож, үйлчилгээ авах боломж бүрдэж байгаа ч хэрэглээ бага, дунджаар 10 орчим хувь нь идэвхтэй ачаалал үүсгэж байна.

Нийт суурин телефон хэрэглэгчийн 90.6 хувь нь өрхийн, 9.3 хувь нь байгууллагын хэрэглэгч байна. Өрхийн хэрэглэгчдийн 87.2 хувь нь АйПиТВ үйлчилгээндээс ярианы үйлчилгээ авч буй бол эсрэгээр байгууллагын хэрэглэгчдийн 87.5 хувь нь бусад суурин холбооны үйлчилгээ эрхлэгчдээс үйлчилгээ авч байна.

Хүснэгт 29. Суурин телефон хэрэглэгчийн тоо, хэрэглэгчийн төрлөөр, 2023 он

	Өрх		Байгууллага		Нийт	
	Тоо	%	Тоо	%	Тоо	%
Нийт хэрэглэгчийн тоо	475,055	100%	48,953	100%	524,075	100%
IPTV үйлчилгээний хүрээнд	414,309	87.2%	6,106	12.5%	420,415	80.2%
Бусад	60,746	12.8%	42,847	87.5%	103,593	19.8%

Суурин телефон хэрэглэгчийн 81.3 хувь нь Улаанбаатар, 18.7 хувь нь орон нутгийн хэрэглэгч байна.

Хүснэгт 30. Суурин телефон хэрэглэгчийн тоо, байршлаар

	Улаанбаатар	Орон нутаг	Нийт
Хэрэглэгчийн тоо	426,331	97,744	524,075
Эзлэх хувь	81.3%	18.7%	100%

7.3 Суурин телефон үйлчилгээний ачаалал


Суурин холбооны ярианы ачаалал 2020, 2021 онд бага зэрэг өссөн бол 2022 онд 45 хувиар, 2023 онд өмнөх оноос 0.6 хувиар тус тус буурчээ.

Суурин телефон сүлжээн доторх ачаалал 2023 онд 19.1 сая минут болж, 13.92 хувиар, гарах ярианы ачаалал 82.6 сая минут болж 2.65 хувиар тус тус буурсан, орох ярианы ачаалал 140.6 сая минут болж 2.92 хувиар өссөн байна.

Орох, гарах ачааллын байдлаас үзвэл суурин телефон дугаараас гадагш ярих хандлага буурч, эсрэгээр суурин телефон дугаар луу залгах хандлага нэмэгдэж, хэрэглэгчийн зан төлөвт гарч буй өөрчлөлт энэ онд хадгалагдаж байна.

Суурин холбооны ачааллын тоо хэмжээг хэрэглэгчийн тоонд харьцуулбал нэг хэрэглэгч хоногт дунджаар 2.7 минутын ярианы ачаалал үүсгэсэн байна.

Зураг 36. Суурин холбооны ярианы ачаалал /сая минут/



8. Өргөн нэвтрүүлэг - Олон суваг дамжуулах үйлчилгээ

Олон суваг дамжуулах үйлчилгээний нийт 30 тусгай зөвшөөрөл эзэмшигч хиймэл дагуул, АйПиТВ, утасгүй газрын сүлжээ, ОТТ технологи ашиглан телевизийн олон суваг дамжуулах үйлчилгээг зах зээлд үзүүлж байна.

Идэвхтэй хэрэглэгчийн тоогоор зах зээлд эзлэх хувийг Монгол Улс, Улаанбаатар хот болон орон нутагт гэж тооцвол 8 компани нийт зах зээлийн 97.58 хувийг бүрдүүлж байна. (хүснэгт 31)

Хүснэгт 31. Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчийн зах зээлд эзлэх хувь, идэвхтэй хэрэглэгчийн тоогоор, 2023 он

№	Тусгай зөвшөөрөл эзэмшигч	Монгол Улс		Улаанбаатар		Орон нутаг	
		Тоо	Эзлэх хувь	Тоо	Эзлэх хувь	Тоо	Эзлэх хувь
1	Юнивишн ХХК	377,113	49.50%	287,684	64.25%	89,429	28.47%
2	ДДэш ТВ ХХК	243,854	32.01%	65,247	14.57%	178,607	56.87%
3	Скаймедиа ХХК	51,977	6.82%	44,710	9.99%	7,267	2.31%
4	Эн Би Си ХХК	24,295	3.19%	24,295	5.43%	-	0.00%
5	Монголсат нэтворкс ХХК	18,765	2.46%	4,729	1.06%	14,036	4.47%
6	Монголын цахилгаан холбоо ХК	12,212	1.60%	12,212	2.73%	-	0.00%
7	Шинэ сансар кабель	8,252	1.08%	973	0.22%	7,279	2.32%
8	Сансар Дижитал ХХК	6,877	0.90%	6,877	1.54%	-	0.00%
	Нийт		97.58%		99.77%		94.45%

8.1 Олон суваг дамжуулах үйлчилгээний орлого


Олон суваг дамжуулах үйлчилгээний орлого 2023 онд өмнөх оноос 17.39 хувиар өсч 212.8 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт харилцаа холбооны үйлчилгээний орлогын 10.14 хувийг эзэлж байна. Төсөвт төвлөрүүлсэн орлого 50.8 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оноос 4.13 хувиар өсчээ.

2023 онд нийт олон суваг дамжуулах үйлчилгээнд 17.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт оруулсны 90.1 хувийг АйПиТВ үйлчилгээнд оруулжээ. Нийт хөрөнгө оруулалт өмнөх оноос 25.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 32. Олон суваг дамжуулах үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт, сүүлийн 3 жилийн өөрчлөлт


Үзүүлэлт		2021		2022		2023		Өмнөх оноос өөрчлөлтийн %
		Тэрбум төгрөг	Нийт дүнд эзлэх %	Тэрбум төгрөг	Нийт дүнд эзлэх %	Тэрбум төгрөг	Нийт дүнд эзлэх %	
Орлого	Нийт	158.33	9.64%	181.26	9.75%	212.77	10.14	17.38%
	IPTV	91.34	5.56%	117.57	6.32%	144.95	6.91%	23.29%
	Хиймэл дагуул, КаТВ	66.99	4.08%	63.69	3.43%	67.82	3.23%	6.48%
Төсөвт төвлөрүүлсэн орлого	Нийт	40.06	13.32%	48.8	15.04%	50.81	14.26	4.12%
	IPTV	26.88	8.94%	35.79	11.03%	39.29	11.02%	9.78%
	Хиймэл дагуул, КаТВ	13.18	4.38%	13.01	4.01%	11.52	3.23%	-11.45%
Хөрөнгө оруулалт	Нийт	35.81	12.85%	25.9	7.06%	19.25	5.69%	-25.68%
	IPTV	33.62	12.07%	23.11	6.30%	17.33	5.13%	-25.01%
	Хиймэл дагуул, КаТВ	2.19	0.78%	2.79	0.76%	1.91	0.57%	-31.54%

Зураг 37. Олон суваг дамжуулах үйлчилгээний нийт орлого /тэрбум.төг/



АйПиТВ үйлчилгээний нэг хэрэглэгчээс нэг сард олох дундаж орлогыг (ARPU) тооцоолоход 2023 онд 28,151 төгрөг байгаа нь өмнөх оноос 7.12 хувиар, бусад олон суваг дамжуулах үйлчилгээний хувьд 2023 онд 16,988 төгрөг болж 20.36 хувиар тус тус өссөн байна. (зураг 37)


Зураг 38. Олон суваг дамжуулах үйлчилгээний нэг хэрэглэгчээс олох дундаж орлого (ARPU) /төгрөг/



8.2 Олон суваг дамжуулах үйлчилгээний хэрэглэгчийн тоо

Телевизийн олон суваг дамжуулах үйлчилгээний идэвхтэй хэрэглэгч 2023 онд 761,800 болж өмнөх оноос 0.23 хувиар өссөн байна. Хэрэглэгчийн тоог технологийн төрлөөр авч үзвэл АйПиТВ хэрэглэгчийн тоо өсч, бусад технологийн хувьд буурсан үзүүлэлттэй байна.


Зураг 39. Олон суваг дамжуулах үйлчилгээний идэвхтэй хэрэглэгчийн тоо



* Үүнд РТГС болон ОТТ үйлчилгээний хэрэглэгчийн тоо ороогүй болно.


Нийт хэрэглэгчийн 98.49 хувь нь өрхийн хэрэглэгч ба Монгол Улсын нийт өрхийн тоотой харьцуулбал 77.46 хувь нь телевизийн олон суваг дамжуулах үйлчилгээг хүлээн авч үзэж байна.

Зураг 40. Олон суваг дамжуулах хэрэглэгчийн тоо, байршлаар




Зураг 41. Олон суваг дамжуулах хэрэглэгчийн тоо, байршил ба технологиор, 2023 он

Улаанбаатарт




Орон нутагт




Телевизийн олон суваг дамжуулах үйлчилгээг технологиор нь авч үзвэл нийт хэрэглэгчийн 56.33 хувь нь АйПиТВ-ээр, 34.47 хувь нь хиймэл дагуулаар, 9.20 хувь нь кабелийн телевизээр үйлчилгээг хүлээн авч үзэж байна. (зураг 42) 2022 оноос нийт хэрэглэгчийн сонгож буй технологид АйПиТВ-ийн эзлэх хувь давамгайлж эхэлж байна. Гэхдээ орон нутгийн хувьд хиймэл дагуулын сонголт давамгайлсан хэвээр байна.

Зураг 42. Олон суваг дамжуулах үйлчилгээний хэрэглэгч, технологийн төрлөөр



АйПиТВ үйлчилгээний хэрэглэгч 2023 онд 429,090 болж 15.10 хувиар өссөн ба үүнээс 97.01 хувь нь гурвалсан үйлчилгээний хэрэглэгч байна. Орон нутаг дахь АйПиТВ үйлчилгээний хэрэглэгчийн тоо өмнөх оноос 0.22 хувиар буурсан.

Зураг 43. АйПиТВ үйлчилгээний нийт хэрэглэгчийн тоо, оноор



Хүснэгт 33. АйПиТВ үйлчилгээний хэрэглэгчийн тоо, төрлөөр

Он	IPTV	IPTV+VOIP	IPTV+VOIP+INTERNET	IPTV+VOIP+INTERNET+WiMax/Mobile	НИЙТ
2018 он	14,873	2,666	218,855	0	236,394
2019 он	20,153	2,859	226,595	1,249	250,856
2020 он	7,063	426	252,345	1,056	260,890
2021 он	6,796	2,564	310,683	1,689	321,732
2022 он	8,806	1,420	360,076	2,507	372,809
2023 он	8,588	2,048	416,354	2,100	429,090

Зураг 44 АйПуТВ хэрэглэгчийн тоо, байршлаар



Олон суваг дамжуулах үйлчилгээний нийт хэрэглэгчийн тоог өрхийн тоотой харьцуулбал нэвтрэлт 77.46 хувь, Улаанбаатар хотод 96.28 хувь, аймгуудаас хамгийн өндөр нь Орхон аймаг 93.21 хувьтай, харин хамгийн бага нь Баян-Өлгий аймаг 39.63 хувьтай байна.

Хүснэгт 34. Олон суваг дамжуулах үйлчилгээний хэрэглэгчийн тоо, хот, аймаг бүсээр

Аймаг, хот	Идэвхтэй хэрэглэгчийн тоо	Өрхийн тоо	Өрхийн нэвтрэлт
НИЙТ	761,800	983,485	77.46%
УЛААНБААТАР	447,738	465,059	96.28%
БАРУУН БҮС	57,528	111,637	51.53%
БАЯН-ӨЛГИЙ	10,433	26,329	39.63%
ГОВЬ-АЛТАЙ	9,159	16,430	55.75%
ЗАВХАН	12,547	21,710	57.79%
УВС	12,874	22,950	56.10%
ХОВД	12,515	24,218	51.68%
ХАНГАЙН БҮС	113,436	179,321	63.26%
АРХАНГАЙ	15,346	28,257	54.31%
БАЯНХОНГОР	14,634	27,101	54.00%
БУЛГАН	10,273	19,328	53.15%
ОРХОН	27,969	30,005	93.21%
ӨВӨРХАНГАЙ	20,840	34,448	60.50%
ХӨВСГӨЛ	24,374	40,182	60.66%
ТӨВИЙН БҮС	98,963	156,784	63.12%

ГОВЬСҮМБЭР	3,597	5,390	66.73%
ДАРХАН -УУЛ	20,190	30,434	66.34%
ДОРНОГОВЬ	8,765	21,543	40.69%
ДУНДГОВЬ	14,598	14,875	98.14%
ӨМНӨГОВЬ	16,035	25,336	63.29%
СЭЛЭНГЭ	19,187	30,361	63.20%
ТӨВ	16,591	28,845	57.52%
ЗҮҮН БҮС	44,135	70,684	62.44%
ДОРНОД	17,611	25,347	69.48%
СҮХБААТАР	11,321	19,481	58.11%
ХЭНТИЙ	15,203	25,856	58.80%

*Эх сурвалж: 2023 оны байдлаар өрхийн тоог 12.12.тн

9. Телевизийн үйлчилгээ

Телевизийн үйлчилгээний тусгай зөвшөөрлийн хүрээнд улсын хэмжээнд нийт 139 телевиз ажиллаж байна. Үүнээс 48 нь орон нутагт буюу тухайн аймаг, суманд хамрах хүрээтэй телевизүүд байна.

2023 онд орон нутгийн 2, Улаанбаатарын 4 телевизийн тусгай зөвшөөрлийг цуцалсан ба төлбөртэй телевизийн үйлчилгээнд 10 тусгай зөвшөөрөл олгосон.

Хүснэгт 35. Телевизийн тусгай зөвшөөрлийн тоо, төрөл, хамрах хүрээгээр


Хамрах хүрээ	Олон нийтийн	Өргөн нэвтрүүлгийн	Арилжааны	Төлбөртэй	Нийт
Улаанбаатар/ Монгол Улс	5	18	48	20	91
Орон нутагт		45	3		48
Нийт	5	63	51	20	139

Телевизийн үйлчилгээний нийт орлого (Олон нийтийн телевизийг оруулахгүйгээр) 2023 онд 95.70 тэрбум байгаа нь өмнөх оноос 23.82 хувиар өссөн. Үүний 64.26 хувийг өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн орлого эзэлж байна.

Өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн орлого 2023 онд 61.48 тэрбум болж, өмнөх оноос 11.16 хувиар өссөн бол арилжааны болон төлбөртэй телевизүүдийн орлого 34.22 тэрбум болж 54.62 хувиар өссөн. (хүснэгт 35)

2023 онд телевизүүд 5.2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн нь өмнөх онтой харьцуулахад 12 тэрбум төгрөгөөр буурсан бөгөөд өмнөх онд төлбөртэй телевизийн хөрөнгө оруулалт голлох хувийг эзэлж байсан байна.

Зураг 45. Телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн орлого /тэрбум төгрөг/



Хүснэгт 36. Телевизийн үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт, сүүлийн 3 жилийн өөрчлөлт

Үзүүлэлт		2021		2022		2023		Өмнөх оноос өөрчлөлтийн %
		Тэрбум төгрөг	Нийт дүнд эзлэх %	Тэрбум төгрөг	Нийт дүнд эзлэх %	Тэрбум төгрөг	Нийт дүнд эзлэх %	
Орлого	Нийт	69.70	4.24%	77.30	4.15%	95.70	3.12%	23.82%
	Өргөн нэвтрүүлгийн ТВ	44.33	2.70%	55.31	2.97%	61.48	2.93%	11.16%
	Арилжааны болон төлбөртэй ТВ	25.37	1.54%	21.99	1.18%	34.22	0.19%	55.62%
Төсөвт төвлөрсөн орлого	Нийт	12.05	4.01%	15.80	4.87%	27.88	5.76%	76.46%
	Өргөн нэвтрүүлгийн ТВ	8.22	2.74%	10.04	3.09%	12.74	3.58%	26.89%
	Арилжааны болон төлбөртэй ТВ	3.83	1.27%	5.76	1.78%	15.14	2.18%	162.85%
Хөрөнгө оруулалт	Нийт	2.09	0.75%	19.24	5.25%	5.20	1.54%	-72.95%
	Өргөн нэвтрүүлгийн ТВ	1.57	0.56%	7.47	2.04%	3.98	1.18%	-46.72%

Арилжааны болон төлбөртэй ТВ	0.52	0.19%	11.77	3.21%	1.21	0.36%	-89.72%
------------------------------	------	-------	-------	-------	------	-------	---------

Нийт телевизийн үйлчилгээний орлогын 64.24 хувийг өргөн нэвтрүүлгийн телевизүүд, 55.87 хувийг УБ хотын өргөн нэвтрүүлгийн телевизүүд бүрдүүлж байна. Харин орон нутгийн телевизүүдийн орлого нийт орлогод 8.68 хувийг эзэлж байна.

Хүснэгт 37. Телевизийн үйлчилгээний 2023 оны орлого /Тэрбум төгрөг/

	Өргөн нэвтрүүлгийн ТВ	Арилжааны болон төлбөртэй ТВ	Нийт	%
Улаанбаатар/Монгол Улс	53.47	33.92	87.41	91.32%
Орон нутгийн	8.01	0.30	8.31	8.68%
Нийт	61.48	34.22	95.70	100%
%	64.24%	35.76%	100%	

Телевизүүд 2023 онд зар сурталчилгаанаас 27.45 тэрбум төгрөгийн орлого олсон нь өмнөх оноос 18 орчим хувиар буурсан байна. Нийт телевизийн орлогод эзлэх зар сурталчилгааны орлого 2022 онд 44.6 хувь байсан бол 2023 онд 28.81 төгрөг болсон байна. (Хүснэгт 38)

Хүснэгт 38. Телевизийн үйлчилгээний 2023 оны орлогын бүтэц

Нийт телевизийн орлогын бүтэц	Орлогын хэмжээ, Төгрөг	Эзлэх хувь
Ивээн тэтгэлт, бүтээгдэхүүн байршуулалт	28,225,885	29.62%
Зар сурталчилгаа, үгэн зар	27,456,968	28.81%
Бусад	12,708,541	13.33%
ӨНТВ-ийн үйлчилгээний хөлс	11,948,150	12.54%
Төлбөрт, захиалгат, бусад нэвтрүүлэг	6,263,322	6.57%
Арилжаа сурталчилгааны нэвтрүүлэг, бизнес мэдээ	5,950,260	6.24%
Өөрийн бүтээл борлуулалт	1,914,463	2.01%
Цаг үеийн мэдээ	543,263	0.57%
Теле худалдааны нэвтрүүлэг	297,660	0.31%
Нийт	95,308,512	100.00%

Өргөн нэвтрүүлгийн телевизүүд 2023 онд зар сурталчилгаанаас 17.08 тэрбум төгрөгийн орлого олсон нь нийт орлогынх нь 27.78 хувийг эзэлж байгаа бол өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний хөлсний орлого 19.43 хувийг эзэлж байна. (Хүснэгт 39)

Хүснэгт 39. Өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн 2023 оны орлогын бүтэц

Өргөн нэвтрүүлгийн телевизүүдийн орлогын бүтэц	НИЙТ		Улаанбаатар		Орон нутаг	
	Төгрөг	Эзлэх хувь	Төгрөг	Эзлэх хувь	Төгрөг	Эзлэх хувь
Зар сурталчилгаа, үгэн зар	17,077,749	27.78%	15,052,381	28.15%	2,025,368	25.28%
ӨНТВ-ийн үйлчилгээний хөлс	11,948,150	19.43%	11,218,236	20.98%	729,915	9.11%
Ивээн тэтгэлт, бүтээгдэхүүн байршуулалт	10,447,776	16.99%	10,184,317	19.05%	263,459	3.29%
Бусад	9,431,814	15.34%	5,942,082	11.11%	3,489,732	43.56%
Төлбөрт, захиалгат, бусад нэвтрүүлэг	5,605,326	9.12%	4,613,656	8.63%	991,670	12.38%
Арилжаа сурталчилгааны нэвтрүүлэг, бизнес мэдээ	5,497,041	8.94%	5,264,887	9.85%	232,154	2.90%
Өөрийн бүтээл борлуулалт	891,240	1.45%	681,641	1.27%	209,599	2.62%
Цаг үеийн мэдээ	537,242	0.87%	468,388	0.88%	68,854	0.86%
Теле худалдааны нэвтрүүлэг	43,839	0.07%	43,539	0.08%	300	0.00%
Нийт	61,480,177	100.00%	53,469,127	100.00%	8,011,050	100.00%

Арилжааны телевизүүд 2023 онд зар сурталчилгаанаас 10.38 тэрбум төгрөгийн орлого олсон нь нийт орлогынх нь 30.68 хувийг эзэлж байгаа бол ивээн тэтгэлт, бүтээгдэхүүн байршуулалтын үйлчилгээний орлого 52.55 хувийг эзэлж байна. (Хүснэгт 40)

Хүснэгт 40. Арилжааны телевизүүдийн 2023 оны орлогын бүтэц

Арилжааны телевизүүдийн орлогын бүтэц	НИЙТ		Улаанбаатар		Орон нутаг*	
	Төгрөг	Эзлэх хувь	Төгрөг	Эзлэх хувь	Төгрөг	Эзлэх хувь
Ивээн тэтгэлт, бүтээгдэхүүн байршуулалт	17,778,110	52.55%	17,776,150	52.62%	1,960	4.21%
Зар сурталчилгаа, үгэн зар	10,379,219	30.68%	10,368,139	30.69%	11,080	23.80%
Бусад	3,274,449	9.68%	3,276,727	9.66%	10,821	23.25%
Өөрийн бүтээл борлуулалт	1,023,223	3.02%	1,021,593	3.02%	1,630	3.50%
Төлбөрт, захиалгат, бусад нэвтрүүлэг	657,995	1.95%	649,944	1.92%	8,051	17.30%
Арилжаа сурталчилгааны нэвтрүүлэг, бизнес мэдээ	453,219	1.34%	443,615	1.31%	9,604	20.63%
Теле худалдааны нэвтрүүлэг	253,821	0.75%	253,821	0.75%	-	0.00%
Цаг үеийн мэдээ	6,022	0.02%	2,622	0.01%	3,400	7.30%
Нийт	33,828,335	100%	33,781,789	100%	46,546	100%

*Орон нутагт нийт 3 арилжааны ТВ үйл ажиллагаа эрхэлж байна.

10. Радиогийн үйлчилгээ

Монгол Улсын хэмжээнд тусгай зөвшөөрлийн хүрээнд нийт 58 радио байгаагаас 3 нь олон нийтийн, 55 нь арилжааны FM радио байна. Арилжааны FM радиогийн 32 нь Улаанбаатар хотод байршилтай ба үүнээс 3 нь Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэйгээр, хиймэл дагуул болон FM радио давтамж ашиглан нэвтрүүлгээ орон даяар дамжуулж байна. Нийт 12 аймагт орон нутгийн 23 FM радио ажиллаж байна.


2023 онд Зохицуулах хорооноос Дорноговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Хэнтий аймгуудад тус бүр нэг, нийт 6 FM радиогийн зөвшөөрөл олгосон бол нэг зөвшөөрлийг цуцалж, 5 зөвшөөрлийн хугацаа дуусгавар болжээ.

Хүснэгт 41. Радиогийн тусгай зөвшөөрлийн тоо, төрөл, хамрах хүрээгээр

Хамрах хүрээ	Олон нийтийн радио	Арилжааны радио (FM)	Нийт
Монгол Улс	3	3	6
Улаанбаатар		29	29
Орон нутагт		23	23
Нийт	3	55	58

Радиогийн үйлчилгээний орлого 2022 онд 51.53 хувиар өссөн бол 2023 онд 19.88 хувь өссөн байна. Төсөвт төвлөрүүлсэн орлого, хөрөнгө оруулалтын хэмжээ мөн 2023 онд өсчээ. (Хүснэгт 42)

Зураг 46. Радиогийн үйлчилгээний орлого /сая төгрөг/



Хүснэгт 42. Радиогийн үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт, сүүлийн 3 жилийн өөрчлөлт

Үзүүлэлт	2021		2022		2023		Өмнөх оноос өөрчлөлтийн %
	Тэрбум төгрөг	Нийт орлогын дүнд эзлэх %	Тэрбум төгрөг	Нийт орлогын дүнд эзлэх %	Тэрбум төгрөг	Нийт орлогын дүнд эзлэх %	
Орлого	2.16	0.13%	3.27	0.18%	3.92	1.63%	19.88%
Төсөвт төвлөрүүлсэн орлого	0.35	0.12%	0.60	0.18%	1.05	0.30%	75.0%
Хөрөнгө оруулалт	0.45	0.16%	0.61	0.16%	1.11	0.34%	81.97%

Радиогийн үйлчилгээний орлогын 97.95 хувийг Улаанбаатар хотын радиогийн орлого бүрдүүлж байна. (хүснэгт 43)

Радиогийн орлогыг бүрдүүлж байгаа байдал Улаанбаатар, орон нутгийн радиогийн хувьд харилцан ялгаатай бөгөөд Улаанбаатар хотын радиогийн орлогод ивээн тэтгэлт хамгийн өндөр 72.41 хувь эзэлж байна. Харин орон нутгийн радионуудын хувьд зар сурталчилгаа, үгэн зар голлох орлогыг буюу 78.1 хувийг бүрдүүлж байна. (хүснэгт 44)

Хүснэгт 43. Радиогийн үйлчилгээний 2023 оны орлого, байршлаар

Улаанбаатар	Орон нутаг	Нийт
3.84	0.08	3.92
97.95%	2.05%	100%

Хүснэгт 44. Радиогийн үйлчилгээний орлогын бүтэц, 2023 он

Радиогийн орлогын бүтэц	НИЙТ		Улаанбаатар		Орон нутаг	
	Төгрөг	Эзлэх хувь	Төгрөг	Эзлэх хувь	Төгрөг	Эзлэх хувь
Ивээн тэтгэлт	2,783,000	70.93%	2,783,000	72.41%	-	0.00%
Зар сурталчилгаа, үгэн зар	544,072	13.87%	481,174	12.52%	62,898	78.01%
Бусад	411,004	10.47%	407,304	10.60%	3,700	4.59%
Төрийн байгууллагаас орсон орлого	119,620	3.05%	119,620	3.11%	-	0.00%
Арилжаа сурталчилгааны нэвтрүүлэг, бизнес мэдээ	38,970	0.99%	27,720	0.72%	11,250	13.97%
Төлбөрт, захиалгат, бусад нэвтрүүлэг	24,315	0.62%	22,115	0.58%	2,200	2.73%
Өөрийн бүтээл борлуулалт	2,822	0.07%	2,322	0.06%	500	0.62%
Дүн	3,923,803	100.00%	3,843,255	100.00%	80,548	100.00%

11. Шуудангийн үйлчилгээ

2023 оны жилийн эцсийн байдлаар шуудангийн үйл ажиллагаа эрхлэх нийт 160 тусгай зөвшөөрөл олгосон байна. Хүснэгт 45-д шуудангийн үйл ажиллагааны чиглэл тус бүрээр тусгай зөвшөөрлийн тоог харуулав.

Хүснэгт 45. Шуудангийн тусгай зөвшөөрлийн тоо

Шуудангийн үйл ажиллагааны чиглэлээр	2021	2022	2023
Шуудангийн сүлжээ байгуулах	8	9	12
Дотоодын шуудангийн үйлчилгээ - Үндсэн	6	7	11
Дотоодын шуудангийн үйлчилгээ - Нэмэлт	52	39	30
Улс хоорондын шуудангийн үйлчилгээ - Буухиа	8	8	10
Улс хоорондын шуудангийн үйлчилгээ - Илгээмж	64	65	97
Нийт	138	144	160

Харилцаа холбооны сүлжээ байгуулах, эзэмших, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд шуудангийн сүлжээ байгуулах эрх бүхий, тусгай зөвшөөрөлтэй 8 аж ахуйн нэгж байгаагаас 6 нь хот хооронд, 4 нь хотын дотор, 2 нь улс хооронд сүлжээ байгуулах эрхтэй байна.

Хүснэгт 46. Шуудангийн сүлжээ байгуулах тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн жагсаалт, үйлчилгээний төрлөөр, 2023

№	Шуудангийн сүлжээний тусгай зөвшөөрөл эзэмшигч	Хот хооронд (6)	Хотын дотор (4)	Улс хооронд (2)
1	Монгол Шуудан ХК			
2	Түгээмэл шуурхай шуудан ХХК			
3	Амар экспресс ХХК			
4	Ашид шуудан ХХК			
5	Мон тээвэр сервис ХХК			
6	Монгол инфинити шуудан ХХК			
7	Эрчист гүрэн ХХК			
8	Ти Юу Хүргэлт ХХК			

Улс хоорондын илгээмжийн үйлчилгээг нийт 14 улсад үзүүлж байгаагаас АНУ, БНСУ-ын чиглэлд хамгийн олон үйлчилгээ эрхлэгч үйлчилгээ үзүүлэхээр зөвшөөрөл авсан байна.

Хүснэгт 47. Улс хоорондын илгээмжийн үйлчилгээ үзүүлж буй чиглэл, үйлчилгээ эрхлэгчийн тоо, 2023 он

№	Илгээлт хүргэж буй чиглэл, улс	Илгээлтийн үйлчилгээ эрхлэгчийн тоо	№	Илгээлт хүргэж буй чиглэл, улс	Илгээлтийн үйлчилгээ эрхлэгчийн тоо
1	АНУ	27	8	БНЧУ	2
2	БНСУ	26	9	Австрали	3
3	БНТУ	8	10	ИБУИНВУ	3
4	ХБНГУ	8	11	Польш	1
5	БНХАУ	16	12	Франц	1
6	Швед	3	13	Сингапур	1
7	Япон	4	14	ОХУ	2

11.1 Шуудангийн үйлчилгээний орлого


Шуудангийн үйлчилгээний нийт орлого 2023 онд 40.69 тэрбум болж, өмнөх оноос 16.71 хувиар буурсан бол төсөвт төвлөрүүлсэн орлого 1.35 хувиар буурчээ. Шуудангийн үйлчилгээнд нийт 4.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн нь 2022 оноос 57.73 хувиар буурсан байна.

Хүснэгт 48. Шуудангийн үйлчилгээний орлого, хөрөнгө оруулалт, сүүлийн 3 жилийн өөрчлөлт

Үзүүлэлт	2021		2022		2023		Өмнөх оноос өөрчлөлтийн %
	Тэрбум төгрөг	Нийт дүнд эзлэх %	Тэрбум төгрөг	Нийт дүнд эзлэх %	Тэрбум төгрөг	Нийт дүнд эзлэх %	
Орлого	35.75	2.18%	48.86	2.63%	40.69	1.94%	-16.71%
Төсөвт төвлөрүүлсэн орлого	7.79	2.59%	6.69	2.06%	6.59	1.85%	-1.35%
Хөрөнгө оруулалт	6.72	2.41%	10.89	2.97%	4.60	1.36%	-57.73%

Шуудангийн үйлчилгээнд Монгол Шуудан ХК-ийн орлого ихээхэн хувийг эзэлж ирсэн нь сүүлийн жилүүдэд буурч, 2023 онд 32.15 хувийг эзэлж байна. (зураг 46)

Зураг 47. Шуудангийн нийт үйлчилгээ эрхлэгчид болон Монгол Шуудан ХК-ийн орлогын харьцуулалт, оноор (сая төгрөг)



2023 онд нийт шуудангийн үйлчилгээний орлогод улс хоорондын буухиа шуудан 33.50, илгээлтийн үйлчилгээний орлого 22.80 хувийг бүрдүүлж байна.

Зураг 48. Шуудангийн үйлчилгээний орлогын бүтэц, эзлэх хувиар



11.2 Шуудангийн илгээмж солилцоо

Нийт дотоодын шуудангийн илгээмж² солилцоо 2023 онд 2 хувиар буурсан бол улс хоорондын шуудангийн илгээмж солилцоо 36 хувиар буурчээ.

Хүснэгт 49. Нийт шуудангийн илгээмж солилцооны тоо

	2021 он	2022 он	2023 он
Дотоодын шуудан	3,666,086	3,704,855	3,632,849
Улс хоорондын шуудан	956,723	848,536	543,676

Жич: шуудан солилцооны тоонд орох болон гарах чиглэлийн нийлбэрээр тооцов.

11.2.1 Дотоодын шуудангийн илгээмж солилцоо

Дотоодын шуудангийн илгээмж солилцоог нийт 6 компанийн мэдээлэл бүрдүүлж байгаа ч дийлэнх хувийг Монгол Шуудан ХК-ийн солилцоо эзэлж байна.

Ковидын жилүүдэд буюу 2020, 2021 онд дотоодын илгээлт, боодлын солилцоо 2-3 дахин нэмэгдэж, 2022 онд эргэж буурсан ч ковидын өмнөх жилээс сүүлийн 2 жил өссөн дүнтэй байна.

Хүснэгт 50. Дотоодын шуудангийн илгээмж солилцооны тоо

Илгээмжийн төрөл	Чиглэл	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
Илгээлт (2-50кг)	Гарах	22,352	19,305	19,885	45,594	161,499	149,817	116,280
	Орох	15,604	18,908	19,547	41,179	154,254	146,716	126,442
Боодол (<2кг)	Гарах	38,259	50,990	49,124	61,769	166,428	98,109	86,239
	Орох	10,533	49,682	46,973	54,635	154,337	92,058	98,234
Бичиг захидал	Гарах	1,162,879	1,490,509	1,616,235	1,978,470	1,805,780	2,002,575	2,181,851
	Орох	455,979	641,941	745,951	917,645	814,103	932,560	788,581

Дотоодын бичиг захидлын 4.37 хувь, илгээлтийн 64.16 хувь, боодлын 3.46 хувийг буухиа шуудангаар хүргэж байна.

Хүснэгт 51. Дотоодын буухиа шуудан солилцооны тоо

Илгээмжийн төрөл	Чиглэл	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
Илгээлт (2-50кг)	Гарах	4,091	2,709	1,574	1,145	119,386	62,704	52,938
	Орох	2,862	2,690	1,549	852	119,851	62,985	51,637
Боодол	Гарах	4,490	4,938	2,642	3,084	4,644	4,173	2,896

² Шуудангийн тухай хуулийн 3.1.3. "шуудангийн илгээмж" гэж үйлчлүүлэгчээс шуудангийн сүлжээ ашиглан, хаягласан эзэнд нь хүргүүлэхээр захидал, боодол, илгээлтийн хэлбэрээр хүлээлгэн өгсөн биет зүйлийг;

(<2кг)	Орох	2,743	4,878	2,601	3,061	4,579	3,617	2,467
Бичиг захидал	Гарах	31,473	39,197	26,639	49,545	81,731	75,591	59,235
	Орох	38,912	38,798	26,067	46,166	79,494	73,950	66,049

11.2.2 Улс хоорондын шуудангийн илгээмж солилцоо

Улс хоорондын шуудан солилцоонд бичиг захидлын солилцоо давамгайлдаг байсан бол 2020 онд 4 дахин буурч, дахин дорвитой нэмэгдээгүй байна. Харин илгээлтийн солилцооны орох чиглэл 2020 онд буурсан ч 2021 оноос 3 дахин нэмэгдэж, улс хоорондын шуудан солилцоонд хамгийн их хувийг эзэлж байна.

Улс хоорондын шуудан солилцоонд ерөнхийдөө гадаадаас орох чиглэл нь гарах чиглэлээсээ илүү байдаг байна.

Хүснэгт 52. Улс хоорондын шуудан солилцооны тоо

Илгээмжийн төрөл	Чиглэл	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
Илгээлт (2-50кг)	Гарах	14,453	15,401	13,784	32,431	132,353	65,460	49,854
	Орох	135,237	204,701	219,227	145,887	463,933	442,174	291,430
Боодол (<2кг)	Гарах	12,398	11,287	10,973	7,989	18,954	11,022	7,448
	Орох	143,801	123,875	143,330	190,525	148,816	74,837	46,840
Бичиг захидал	Гарах	181,403	152,090	163,731	23,872	13,180	29,850	15,258
	Орох	108,896	112,498	111,343	39,279	52,092	56,881	16,505

Улс хоорондын бичиг захидлын 20.32 хувь, илгээлтийн 23.77 хувь, боодлын 6.69 хувийг буухиа шуудангаар хүргэж байна.

Улс хоорондын буухиа шуудан солилцоо 2020 онд буурч, 2021 оноос буцаж өссөн ч сүүлийн жил буурч байна.


Хүснэгт 53. Улс хоорондын буухиа шуудан солилцоо

Илгээмжийн төрөл	Чиглэл	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он	2023 он
Илгээлт (2-50кг)	Гарах	23,681	24,020	25,550	18,452	26,608	29,850	15,258
	Орох	57,661	52,142	44,222	23,025	23,101	56,881	16,505
Боодол (<2кг)	Гарах	6,366	6,033	6,695	9,037	12,382	10,192	8,373
	Орох	39,745	38,756	45,472	35,010	62,765	65,271	66,816
Бичиг захидал	Гарах	1,658	2,424	1,145	1,308	1,011	920	973
	Орох	7,590	8,086	5,894	907	1,528	5,198	3,090

12. Хүний нөөц

Харилцаа холбооны үйл ажиллагаа эрхэлж буй тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудад 2023 оны байдлаар нийт 12,232 ажилтан ажиллаж байгаа нь өмнөх оноос 3.6 хувиар буурсан.

Зураг 49. Нийт ажилтны тоо, оноор



Ажиллагсдын тоог салбар, үйлчилгээний төрлөөр нь авч үзвэл үүрэн холбооны үйлчилгээнд хамгийн их буюу 23.4 хувь нь ажиллаж байна. “Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ”-ний ажилтны тоо хүний нөөцийн өсөлтөд гол нөлөө үзүүлсэн бол зарим үйлчилгээ, тухайлбал суурин интернэт, телевиз, радиогийн үйлчилгээний ажилтны тоо бага зэргээр буурчээ.


Хүснэгт 54. Нийт ажилтны тоо, салбар болон үйлчилгээний төрлөөр

Салбар	Үйлчилгээний төрөл	2021		2022		2023		Өмнөх оноос өөрчлөлтийн %
		Тоо	Нийт дүнд эзлэх %	Тоо	Нийт дүнд эзлэх %	Тоо	Нийт дүнд эзлэх %	
Мэдээлэл холбоо	Үүрэн холбоо	2,649	22.69%	2,988	23.55%	2,861	23.4%	-4.25%
	Мэдээлэл холбооны сүлжээ	1,965	16.83%	1,919	15.12%	1,963	16.0%	2.29%
	Суурин холбоо	812	6.96%	807	6.36%	830	6.8%	2.85%
	Суурин интернэт	627	5.37%	547	4.31%	607	5.0%	10.97%
	Сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ	959	8.22%	1,627	12.82%	1,256	10.3%	-22.80%
	Сансрын холбоо	50	0.43%	30	0.24%	39	0.3%	30.00%

Өргөн нэвтрүүлэг	Өргөн нэвтрүүлгийн ТВ	1,371	11.75%	1,358	10.70%	1,301	10.6%	-4.20%
	Арилжааны болон төлбөртэй ТВ	673	5.77%	589	4.64%	570	4.7%	-3.23%
	ОСДҮ - IPTV	572	4.90%	661	5.21%	698	5.7%	5.60%
	ОСДҮ – Хиймэл дагуул, КаТВ	420	3.60%	476	3.75%	427	3.5%	-10.29%
	Арилжааны радио	158	1.35%	138	1.09%	154	1.3%	11.59%
Шуудан	Шуудангийн сүлжээ, үйлчилгээ	1,410	12.08%	1,542	12.15%	1,526	12.5%	-1.04%
Нийт		11,673	100.00%	12,688	100.00%	12,232	100.0%	-3.59%

Ажиллагчдыг хүйсээр нь авч үзвэл эрэгтэй 53.9 хувь, эмэгтэй 46.1 хувийг тус тус эзлэж байна.

Зураг 50. Нийт ажиллагчдын тоо, хүйсээр



Ажиллагчдыг мэргэжлийн чиглэлээр авч үзвэл мэдээллийн технологийн инженер 12.5 хувь, цахилгаан холбооны инженер 7.7 хувь, радио холбооны инженер 4.2 хувийг тус тус эзлэж байна.

Хүснэгт 55. Нийт ажиллагчдын тоо, мэргэжлээр

Үйлчилгээ	Мэдээллийн технологийн инженер	Радио холбооны инженер	Цахилгаан холбооны инженер	Электроникийн инженер	Санхүүч, нягтлан бодогч, Эдийн засагч, шинжээч	Хуульч, эрх зүйч	Маркетингийн мэргэжилтэн	Үйлчилгээний ажилтан	Кабельчин, ОУ тээврийн инженер, шилэн холбооны	Найруулагч, Нэвтрүүлэгч, Оператор, сэтгүүлч	Бусад	Нийт ажиллагчдын тоо
ХХ үйлчилгээ-үүрэн холбоо	323	78	139	47	287	62	82	438			1,405	2,861
Мэдээлэл холбооны сүлжээ (хот, хот хооронд)	171	129	146	46	110	32	14	118	246		860	1,872
Шуудангийн сүлжээ	105	14			129				172		1,106	1,526
Өргөн нэвтрүүлгийн ТВ	102	63			61	14	61			540	460	1,301
ХХ сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт	248	114	148	62	113	22		70			479	1,256
ХХ үйлчилгээ-суурин холбоо	37	48	248	11	65	70		35			316	830
Олон сувгийн дамжуулах үйлчилгээ (IPTV)	98		10	4	19	8		483			76	698
ХХ үйлчилгээ-интернэт	209		72	18	58	14	38				198	607
Арилжааны ТВ	129	45			34	13				226	88	535
Олон сувгийн дамжуулах үйлчилгээ (CATV)	35	12	30	11	47	11	20	45			216	427
Арилжааны радио	13	14			11	3	13			92	8	154
Мэдээлэл холбооны сүлжээ (улс хооронд)	29	8	13	6	6	3		1			18	84
Сансрын холбооны сүлжээ (VSAT) А,Б	6	5		3	4						21	39
Төлбөртэй ТВ	22	2			2					5	4	35
Мэдээллийн сүлжээ-контент	6						1				0	7
Нийт	1,533	532	806	208	946	252	229	1,190	418	863	5,255	12,232
Хувь, %	12.53	4.35	6.59	1.70	7.73	2.06	1.87	9.73	3.42	7.06	42.96	100

Хавсралт

Хавсралт 1. Хэрэглэгчийн тоо, хот, аймаг бүсээр, 2023 он

Хот, бүс, аймаг	Хүн ам	Өрх	Идэвхтэй хэрэглэгчийн тоо					
			Үүрэн холбоо	3G	4G/LTE	Хөдөлгөөнт өргөн зурвас	ISP	ОСДҮ
НИЙТ	3,504,741	983,485	4,841,935	3,575,115	3,447,287	4,122,366	498,889	761,800
БАРУУН БҮС	419,864	111,637	467,887	290,283	288,606	366,395	16,123	57,528
БАЯН-ӨЛГИЙ	116,615	26,329	106,148	67,201	72,729	86,590	2,811	10,433
ГОВЬ-АЛТАЙ	56,752	16,430	71,102	43,723	42,539	56,066	3,082	9,159
ЗАВХАН	71,126	21,710	94,118	52,636	47,197	66,932	1,856	12,547
УВС	83,914	22,950	93,791	58,769	60,569	75,713	3,646	12,874
ХОВД	91,457	24,218	102,728	67,954	65,572	81,094	4,728	12,515
ХАНГАЙН БҮС	602,959	179,321	676,070	453,743	434,496	534,651	41,423	113,436
АРХАНГАЙ	92,343	28,257	103,556	60,577	63,529	73,307	3,046	15,346
БАЯНХОНГОР	88,166	27,101	97,300	62,123	59,625	76,435	5,198	14,634
БУЛГАН	60,535	19,328	63,659	44,622	42,986	54,278	2,129	10,273
ОРХОН	110,440	30,005	121,215	100,732	96,764	114,170	21,009	27,969
ӨВӨРХАНГАЙ	114,630	34,448	121,326	90,521	77,128	97,088	3,732	20,840
ХӨВСГӨЛ	136,845	40,182	169,014	95,168	94,464	119,373	6,309	24,374
ТӨВИЙН БҮС	518,227	156,784	714,787	605,616	541,262	653,904	47,602	98,963
ГОВЬСҮМБЭР	18,042	5,390	21,328	17,242	15,947	20,030	2,379	3,597
ДАРХАН -УУЛ	109,236	30,434	126,967	99,440	96,425	119,275	16,579	20,190
ДОРНОГОВЬ	71,517	21,543	107,393	94,285	79,689	103,521	7,651	8,765
ДУНДГОВЬ	46,092	14,875	56,045	38,115	32,608	42,408	1,974	14,598
ӨМНӨГОВЬ	75,198	25,336	169,525	136,681	139,342	163,101	8,385	16,035
СЭЛЭНГЭ	106,691	30,361	117,434	107,154	93,993	110,295	6,861	19,187
ТӨВ	91,451	28,845	116,095	112,699	83,258	95,274	3,773	16,591
ЗҮҮН БҮС	228,843	70,684	303,324	205,589	183,311	243,728	14,424	44,135
ДОРНОД	84,053	25,347	102,660	77,993	71,024	87,449	7,955	17,611
СҮХБААТАР	65,696	19,481	83,747	49,815	52,439	69,695	2,394	11,321
ХЭНТИЙ	79,094	25,856	116,917	77,781	59,848	86,584	4,075	15,203
УЛААНБААТАР	1,734,848	465,059	2,679,867	2,019,884	1,999,612	2,323,688	379,317	447,738

Хавсралт 2. Харилцаа холбооны тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээний үндсэн үзүүлэлтүүд, сүүлийн 2 жилд

Үзүүлэлтүүд	2022	2023	Өөрчлөлт
Үүрэн холбооны үйлчилгээ			
Идэвхтэй хэрэглэгчийн тоо	4,835,520	4,841,935	0.1%
- иргэн	4,112,678	4,141,688	0.7%
- байгууллага	722,842	700,247	-3.1%
Үүрэн холбооны ярианы нийт ачаалал (сая минут)	12,420	12,674	2.1%
Үүрэн холбооны сүлжээнд илгээгдсэн мессежний тоо (сая ширхэг)	841.3	753.0	-10.5%
Үүрэн холбооны 100 хүнд ногдох хэрэглэгч	141.8%	138.2%	-3.6 н.х
Үүрэн холбооны орлого (тэрбум.төг)	1,040	1,191	14.5%
Үүрэн холбооны нэг хэрэглэгчээс олох дундаж орлого, төг	14,372	16,544	15.1%
Суурин холбооны үйлчилгээ			
Ачаалал үүсгэсэн идэвхтэй хэрэглэгчийн тоо,	190,305	190,604	0.2%
Төлбөр төлсөн идэвхтэй хэрэглэгчийн тоо	475,290	524,075	10.3%
- өрх	426,156	475,055	11.5%
- байгууллага	49,134	49,020	-0.2%
Суурин холбооны ярианы нийт ачаалал, (сая минут)	243.6	242.25	-0.6%
Суурин холбооны 100 хүнд ногдох хэрэглэгч (төлбөр төлсөн)	13.7%	14.9%	1.2 н.х
Суурин холбооны орлого (тэрбум.төг)	32	34	6.6%
Үүрэн холбооны хөдөлгөөнт өргөн зурвасын үйлчилгээ			
Үүрэн холбооны хөдөлгөөнт өргөн зурвасын хэрэглэгчийн тоо	3,996,900	4,122,366	3.1%
- Яриа болон дата хэрэглэгчийн тоо	3,644,821	3,751,283	2.9%
- Зөвхөн дата хэрэглэгчийн тоо	352,079	371,083	5.4%
3G хэрэглэгчийн тоо	3,559,582	3,575,115	0.4%
4G хэрэглэгчийн тоо	3,093,666	3,447,287	11.4%
M2M хэрэглэгчийн тоо	193,135	166,595	-13.7%
Үүрэн холбооны хөдөлгөөнт өргөн зурвасын 100 хүнд ногдох хэрэглэгч	115.5%	117.6%	2.1 н.х
Зөвхөн дата үйлчилгээний 100 хүнд ногдох хэрэглэгч	10.2%	10.6%	0.4 н.х
3G сүлжээн дэх дата ачаалал (Терабайт)	41,425	49,117	18.6%
4G сүлжээн дэх дата ачаалал (Терабайт)	474,596	612,279	29.0%
Дата үйлчилгээний орлого (тэрбум.төг)	325	512	57.5%
Суурин интернэтийн үйлчилгээ			
Суурин интернэт хэрэглэгчийн тоо	436,447	498,889	14.3%
- өрх	411,856	471,729	14.5%
- байгууллага	24,591	27,160	10.4%
Суурин интернэт үйлчилгээний 100 өрхөд ногдох хэрэглэгч	43.7%	48.0%	4.3 н.х
Суурин интернэт үйлчилгээний 100 хүнд ногдох хэрэглэгч	12.6%	14.2%	1.6 н.х
Суурин интернэт үйлчилгээний орлого (тэрбум.төг)	172	199	15.2%
Олон суваг дамжуулах үйлчилгээ			
Олон суваг дамжуулах үйлчилгээний идэвхтэй хэрэглэгчийн тоо	760,028	761,800	0.2%
Олон суваг дамжуулах үйлчилгээний 100 өрхөд ногдох хэрэглэгч	81.7%	76.3%	-5.4 н.х
Олон сувгийн дамжуулах үйлчилгээний орлого (тэрбум.төг)	181	213	17.4%
Шуудангийн үйлчилгээ			
Дотоодын шуудангийн солилцоо (ширхэг)	3,773,605	3,632,849	-3.7%
Улс хоорондын шуудангийн солилцоо (ширхэг)	824,451	543,676	-34.1%
Шуудангийн үйлчилгээний орлого (тэрбум.төг)	49	41	-16.7%
Тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээний нийт орлого (тэрбум.төг)	1,859	2,098	12.8%
Тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээний нийт хөрөнгө оруулалт (тэрбум.төг)	367	338	-7.8%
Тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээний нийт төсөвт төвлөрүүлсэн орлого (тэрбум.төг)	324	356	9.9%
Тусгай зөвшөөрөлтэй үйлчилгээний нийт ажиллагчдын тоо	12,688	12,232	-3.6%

Хавсралт 3. 2023 оны жилийн эцсийн тайлангийн ирц

№	Тусгай зөвшөөрлийн төрөл	ТЗ тоо	Тайлан мэдээ ирүүлсэн	Үйл ажиллагаа явуулаагүй	Шинээр ТЗ авсан	Нийт	Тайлан ирүүлээгүй	Хувь
Мэдээлэл харилцаа холбоо 367	Харилцаа холбооны сүлжээ	20	19	1		20	-	100.00%
	Сансрын холбооны сүлжээ, үйлчилгээ	7	6			6	1	85.71%
	ХХ үйлчилгээ-суурин холбоо	7	7			7	-	100.00%
	ХХ үйлчилгээ-үүрэн холбоо	5	5			5	-	100.00%
	ХХ үйлчилгээ-улс хоорондын яриа	4	4			4	-	100.00%
	ХХ үйлчилгээ-интернэт	61	47	1	6	54	7	88.52%
	Мэдээллийн сүлжээ- контент	6	4		2	6	-	100.00%
	ХХ сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт	267	188	23	16	227	40	85.02%
Өргөн нэвтрүүлэг 228	РТВ-ийн газрын сүлжээ	1	1			1	-	100.00%
	Олон сувгийн дамжуулах үйлчилгээ	30	29		1	30	-	100.00%
	Олон нийтийн ТВ	5	5			5	-	100.00%
	Өргөн нэвтрүүлгийн ТВ	63	55	2		57	6	90.48%
	Арилжааны ТВ	51	48	1		49	2	96.08%
	Төлбөртэй ТВ	20	20			20	-	100.00%
	Олон нийтийн радио	3	3			3	-	100.00%
	Арилжааны радио	55	42	8		50	5	90.91%
Шуудан 160	Шуудангийн сүлжээ, үйлчилгээ	160	80	20	12	112	48	70.00%
Нийт		765	563	56	37	656	109	85.75%